



M

ОНГОЛБАНКНЫ ЭДЭЭЛЭЛ



Монголбанкны үндсэн зорилт нь үндэсний мөнгөн тэмдэгт - төгрөгийн тогтвортой байдлыг хангахад оршино.

2018 • V • № 19

С.ДЭМБЭРЭЛ:
ХҮРТЭЭМЖТЭЙ
ӨСӨЛТИЙГ БИЙ
БОЛГОЁ ГЭВЭЛ
ХҮМҮҮСИЙН
АМЬДРАЛЫГ
МЭДДЭГ
БАЙХ ЁСТОЙ

МӨНГӨНИЙ
БОДЛОГЫГ
ХАМТЫН
ЗАРЧМААР
ГАРГАХ НЬ

"ЭДИЙН
ЗАСГИЙН
ӨНӨӨГИЙН
БАЙДАЛ,
ЦААШДЫН ЧИГ
ХАНДЛАГА-2018"
ХЭЛЭЛЦҮҮЛГИЙН
ТОЙМ



ЭРДЭНЭСИЙН САНГААС: АЛТАН ШАРМАЛ ДОМБО

ЗӨВХӨН АЛБАН ХЭРГЭЭНД



“МОНГОЛЧУУДЫН ТӨЛБӨРИЙН ХЭРЭГСЭЛ-ЭРТНЭЭС ЭДҮГЭЭ ҮЗЭСГЭЛЭН”

Хүннүгийн үеэс өдгөөг хүртэлх монголчуудын зоос, мөнгөн тэмдэгтийн хэрэглээг харуулсан үзэсгэлэн 14 хоногийн турш Үндэсний түүхийн музейд үүд хаалгаа нээлээ. Монголбанк, Монголын зоос судлалын холбоо хамтран анх 2014 онд тус үзэсгэлэнг гаргаж байсан бол энэ удаад “Монголчуудын төлбөрийн хэрэгсэл эртнээс эдүгээ” сэдвийн дор тус үзэсгэлэнг хоёр дахь удаагаа үзэгчдийн хүртээл болгосон энэ юм. Тавдугаар сарын 14-нөөс 28-ны өдөр нээгдсэн үзэсгэлэнг нийт 8300 гаруй хүн үзэж, сонирхсон байна. Үзэсгэлэнд монголчуудын төлбөрийн хэрэгслийн хөгжил, түүхийг харуулсан 1000 гаруй үзмэр дэлгэн үзүүлсэн юм.



Монголбанкны Олон нийтийн боловсрол, мэдээллийн төвөөс эрхлэн гаргав.

Онцлох мэдээ:

Монголбанкны дэргэд
судалгааны хүрээлэн
байгуулагдав

ХУУДАС

4

Асуулт, хариулт:

Монголбанкны хэвлэлийн
бага хурлаас... /2018.05.23/

ХУУДАС

24

Ярилцлага:

С.Дэмбэрэл: Хүртээмжтэй
есөлтийг бий болгоё гэвэл
хүмүүсийн амьдралыг мэддэг
байх ёстой

ХУУДАС

7

Мөнгөн тэмдэгтийн түүх:

Мөнх хааны мөнгөн зоос

ХУУДАС

30

Индэр:

Монголбанкны "Эдийн засгийн
судалгаа, сургалтын хүрээлэн"-
гийн нээлтэд Монголбанкны
Ерөнхийлөгч Н.Баяртсайханы
хэлсэн үг

ХУУДАС

11

Банкир:

О.Банзрагч: Банкны салбарт төрийн
өмчлөл байх хэрэггүй гэж боддог

ХУУДАС

31

Нийтлэл

Мөнгөний бодлогыг хамтын
зарчмаар гаргах нь

ХУУДАС

16

Мөнгө-Санхүү-Баялаг:

"Эдийн засгийн өнөөгийн байдал,
цаашдын чиг хандлага-2018"
хэлэлцүүлгийн тойм

ХУУДАС

35

**Улаанбаатарын
зөвшилцөл:**

Төсвийн сахилгыг хангах,
үндэсний хуримтлалтай болж,
тууштай нэмэгдүүлэх

ХУУДАС

18

Дэлхийн эдийн засаг:

Аргентин улсын эдийн
засгийн зовлон

ХУУДАС

40

**Монголбанк юу
хийдэг вэ?**

А.Энхтүвшин: Гадаад валютын
улсын нөөц үндэсний мөнгөн
тэмдэгтийн баталгаа болдог

ХУУДАС

22

Санхүүгийн боловсрол:

Та байр авахад бэлэн үү?

ХУУДАС

43

Монголбанкны дэргэд судалгааны хүрээлэн байгуулагдав

Монгол Улсын хэмжээнд эдийн засгийн бодлогын асуудлаар суурь болон эмпирик судалгаа хийх, төрийн бодлого боловсруулагчдад бодлогын зөвлөмж өгөх зорилгоор Монголбанкны дэргэд “Эдийн засгийн судалгаа, сургалтын хүрээлэн” байгуулагдав. Олон улсын жишигт төв банк дэргэдээ судалгааны төвтэй байхыг өндөр ач холбогдолтой хэмээн үзэж өргөнөөр ашигладаг байна. Манай улсын хувьд шинээр байгуулагдаад буй Монголбанкны дэргэдэх энэхүү хүрээлэнгийн эхний ажил нийгмийн болон бизнесийн орчин, хөдөө орон нутгийн хотжилт, хөгжлийн талаарх судалгаанаас эхэлж байна.



Мөнгөний бодлогын хэрэгжилтийг зорилтдоо хүрсэн болохыг дүгнэв



2017 онд хэрэгжүүлсэн мөнгөний бодлогын үр дүн, хэрэгжилтэд “Монголын эдийн засгийн шинжилгээ, судалгааны төв” хөндлөнгийн судалгаа хийв. Судалгааны дүгнэлтэд 2017 оны турш мөнгөний бодлогын хүүг нийт 3 нэгж хувиар бууруулсан байдал болон мөнгөний бодлогын төлөв нь эдийн засгийн өсөлтийг дэмжихэд чиглэсэн болохыг онцлов. Мөн инфляцийг 8 хувиас дээшгүй түвшинд барих бодлогын зорилтыг хангаж, төлбөрийн тэнцэл 1.5 тэрбум ам.долларын ашигтай гарч, ГВАН 3 тэрбум ам.долларт хүрч нэмэгдсэнээр төгрөгийн гадаад валюттай харьцах ханш тогтворжсон зэрэг нааштай үр дүнд хүрсэн. 2018 он гарсаар бодлогын хүүг дахин 1 нэгж хувиар бууруулж, 10 хувьд хүргэсэн нь мөнгөний бодлогын төлөв цаашид ч эдийн засгийн өсөлтийг дэмжих, зээлийн хүүгийн түвшинг бууруулах чиглэлтэй байгааг судалгаанд дүгнэжээ.

ОУВС-ийн дөрөв дэх шатны үнэлгээг хийх ажлын хэсэг Монгол Улсад ажиллалаа

ОУВС-ийн “Өргөтгөсөн санхүүжилтийн хөтөлбөр”-ийн дөрөв дэх шатны үнэлгээг Жэф Готтлийбэрээр хийх ажлын хэсэг тавдугаар сарын 2-14 нд Монгол Улсад ажилласан бөгөөд хөтөлбөрийн хэрэгжилтийн явц, үр дүн, тайлан мэдээлэл, тоон үзүүлэлтэд дүн шинжилгээ хийж, Засгийн газар, Монголбанкны албаны хүмүүстэй уулзалт хийв. ОУВС-тай тохиролцсон хөтөлбөрийн дагуу тус сангаас хөтөлбөрийн хэрэгжилтэд улирал тутамд үнэлгээ хийж, дараах санхүүжилтийг олгодог болно.



Монголбанк хамтын удирдлагын зарчмаар бодлогын шийдвэрээ гаргадаг болов



Төв банк (Монголбанк)-ны тухай хуулийн нэмэлт өөрчлөлтөөр Монголбанкны Мөнгөний бодлогын зөвлөлийг Мөнгөний бодлогын хороо болгон өөрчилж, бодлогын шийдвэрийг хамтын удирдлагын зарчмаар хэлэлцэн баталдаг болсон бөгөөд тус хороо орон тооны болон орон тооны бус долоо гишүүнээс бүрдэх юм. Тэгвэл Мөнгөний бодлогын хорооны орон тооны бус 3 гишүүн тавдугаар сард хуульд заасны дагуу УИХ-аас томиллоо. Мөн хуулийн дагуу Банкны хяналт шалгалтын хороог тавдугаар сард байгуулж анхны хурлаа хийсэн юм. Уг хороо нь банкны хяналттай холбоотой тодорхой асуудлуудаар Төв банкны удирдлагад зөвлөмж өгч ажиллана.

Монголбанк ипотекийн зээлд 45 тэрбум төгрөгийг банкуудад хуваарилав

Ипотекийн зээлийн санхүүжилтэд Монголбанкнаас 15.7 тэрбум, Засгийн газраас 29.4 тэрбум төгрөгийн санхүүжилт 5 дугаар сарын 4-нд хийгдлээ. Тус санхүүжилтэд нийт 657 иргэн хамрагдаад байна. Монголбанк болон Засгийн газар ипотекийн санхүүжилтийг сард хоёр удаа тогтмол олгож байгаа бөгөөд 2018 он гарснаас хойш нэгдүгээр улирлын байдлаар 48.1 тэрбум төгрөгийн санхүүжилтийг банкуудад хуваарилж, 706 иргэн хамрагдсан байна.



Хувь хүний санхүүгийн мэдлэг олгох хичээлийн “Сургагч багш” бэлтгэх сургалт зохион байгуулаа



Монголбанк, Санхүүгийн зохицуулах хороо, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам хамтран хувь хүний санхүүгийн мэдлэг олгох хичээлийн “Сургагч багш” бэлтгэх сургалтыг зохион байгуулав. Олон нийтийн санхүүгийн суурь мэдлэгийг дэмжих үндэсний хөтөлбөрийн хүрээнд ХНХЯ-аас мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагуудын сургалтын агуулгад нэмэлтээр “Хувь хүний санхүүгийн мэдлэг”, “Хувь хүний санхүү, бизнес, аж ахуй эрхлэлт” хичээлийг баталсантай холбогдуулж, тус сургалтыг улсын хэмжээнд зохион байгуулж, тавь шахам багш, заах арга зүйч хамрагдав.

Журмын төслүүдэд иргэдээс санал авч эхэллээ



Банкны хүү бодоход баримтлах зарчмыг тодорхойлох, хүү, шимтгэл, хураамжийн мэдээллийг ил тод байлгах, хадгаламж эзэмшигч, харилцагчдын эрх ашгийг хамгаалах зорилгоор “Банкны хүү бодох аргачлал, хүү, шимтгэл, хураамжийн мэдээллийн ил тод байдлын журам”-ын төсөл болон Монгол Улсын Их Хурлын чуулганы 2018 оны 01 сарын 18-ны өдрийн хуралдаанаар хэлэлцүүлсэн Банкны тухай хуулийн нэмэлт, өөрчлөлтийн хүрээнд “Харилцан хамаарал бүхий этгээд, холбогдох этгээд, төвлөрлийн эрсдэлийн удирдлагын журам”-ын төслийг боловсруулан олон нийтээр хэлэлцүүлж эхэллээ. Захиргааны ерөнхий хуульд олон нийтээс 30-аас доошгүй хоногийн хугацаанд санал авна гэж заасны дагуу танилцуулж байгаа юм.

Монголбанкны Эрдэм шинжилгээний бага хурал болов

Монголбанкнаас жил бүр зохион байгуулж ирсэн “Эрдэм шинжилгээний бага хурал” 2018 оны 05-р сарын 29-ний өдөр амжилттай болж өндөрлөлөө. Тус эрдэм шинжилгээний бага хурал нь эдийн засгийн чиглэлээр сурч буй оюутан, судлаачдын судалгаа хийх чадварыг дэмжих, бүтээлийг нийтэд түгээн дэлгэрүүлж, бодлого боловсруулахад тэдний оролцоог нэмэгдүүлэх зорилготой билээ. Энэ удаагийн хурал 2 шаттай явагдаж ирсэн бүтээлүүдийн тоо чанараас хамаарч хоёрдугаар шатанд оюутны ангилалд 3 бүтээл, судлаачдын ангилалд 5 бүтээл шалгарсан бөгөөд судлаачдын ангилалд 3, оюутны ангилалд 2 бүтээл шилдгээр шалгарлаа.



Бага дүнтэй гүйлгээний системийг олон улсын стандартад нийцүүлнэ



Азийн Хөгжлийн Банкны санхүүжилтээр Монголбанкинд хэрэгжиж буй “Төлбөрийн системийн шинэчлэл” төслийн хүрээнд банк хоорондын бага дүнтэй гүйлгээний системд олон улсын стандартад нийцсэн “Автомат Клиринг Хаус” буюу АСН+ системийг нэвтрүүлэхээр боллоо. Тус системийг нэвтрүүлэх нээлттэй сонгон шалгаруулалтад АНУ-ын “Монтран” корпораци шалгарсан бөгөөд Монголбанк болон тус корпорацийн удирдлагууд 5 дугаар сарын 31-ний өдөр төслийг хэрэгжүүлэх гэрээнд гарын үсэг зурав. Ингэснээр “Монтран” корпораци нь 2018 оны 5 дугаар сараас 2019 оны 8 дугаар сар хүртэлх хугацаанд Монгол Улсын банк хоорондын бага дүнтэй гүйлгээний системийг шинэчилж, олон улсын стандартад нийцүүлэх ажлыг гүйцэтгэхээр болж байна. Банк хоорондын бага дүнтэй гүйлгээний системийг шинэчилснээр төлбөр тооцоо олон улсын стандартад нийцсэн горимоор шуурхай, саадгүй, найдвартай ажиллах нөхцөл бүрдэх юм.

**БОЛОВСРОЛ:**

1964 - 1974 онд Нийслэлийн 10 жилийн 33 дугаар дунд сургууль

1978 - 1981 онд Монгол Улсын Их Сургуулийн Эдийн засгийн факультет тус тус төгссөн.

АЖЛЫН ТУРШЛАГА:

1981-1984 онд Комплекс импорт нэгдэлд ня-бо

1984-1990 онд Эдийн засгийн хүрээлэнд эрдэм шинжилгээний ажилтан

1990-1997 онд Зах зээл судлалын хүрээлэнд эрдэм шинжилгээний ахлах ажилтан

1997 онд Зах зээл судлалын хүрээлэнгийн захирал

1997-2012 онд Монголын Үндэсний Худалдаа Аж Үйлдвэрийн Танхимын дарга

2012-2016 онд Монгол Улсын Их Хурлын гишүүн

2016-2018 онд Зах зээл судлалын хүрээлэнгийн захирал

2018.05-р сараас Монголбанкны Эдийн засгийн судалгаа, сургалтын хүрээлэнгийн захирал

С.ДЭМБЭРЭЛ: ХҮРТЭЭМЖТЭЙ ӨСӨЛТИЙГ БИЙ БОЛГОЁ ГЭВЭЛ ХҮМҮҮСИЙН АМЬДРАЛЫГ МЭДДЭГ БАЙХ ЁСТОЙ

Монголбанкны Эдийн засгийн судалгаа, сургалтын хүрээлэнгийн захирал С.Дэмбэрэлтэй ярилцлаа.

» Эдийн засгийн судалгаа, сургалтын хүрээлэнгийн захирлаар томилогдоод удаагүй байна. Хүрээлэнгийн ажил юунаас эхлэх вэ. Та энэ хүрээлэнгийн цаашдын ирээдүйн дүр зургийг хэрхэн харж байна вэ?

-Монголбанкны удирдлага санаачилга гарган бусад улс орны төв банкуудын дэргэд байдаг эдийн засгийн судалгааны хүрээлэнг судлаад, Монголд байгуулах шаардлагатай гэж үзсэн юм билээ. Гол зорилго нь Монголбанк эдийн засгийн өргөн

хэмжээний бодлого явуулах тусам мөнгөний бодлогын үндсэн зорилтыг хангах чанар нь дээшилнэ. Монголбанкны үндсэн зорилт нь хуулиар үндэсний мөнгөн тэмдэгт, төгрөгийн тогтвортой байдлыг хангах. Энэ бол явцуу хүрээнд ойлгох зүйл биш. Инфляци бол нийгмийн амьдралд хамгийн чухал зүйл. Энэ бүхнийг инфляци тойрсон хэдэн тоогоор биш, нийгэм, эдийн засаг, бизнесийн орчин, хэрэглэгчийн сэтгэл санаа гэх зэрэг олон зүйлээр харах ёстой. Тийм учраас нийгэм, эдийн засгийн

олон салбарын судалгаа хэрэгтэй. Монголбанкны Ерөнхийлөгчийн тушаалаар хүрээлэнгийн хийх ажлыг маш тодорхой зааж өгсөн. Өөрөөр хэлбэл, макро эдийн засгийн болон нийгмийн суурь болон эмпирик судалгаануудыг хийнэ. Хүрээлэн байгуулагдаад, нээлт хийх үеэр анхны албан даалгавар өгөгдсөн байгаа. Хүрээлэнгийн хийх ажил, эрдэм шинжилгээ, судалгааны ажлуудын чиглэлийг гаргаад, зөвхөн судалгаа хийгээд орхих бус түүний үр дүн, зөвлөмжүүдийг УИХ, Засгийн газар болон бүх түвшний шийдвэр

гаргагчдад танилцуулж, хүргэж ажиллах юм. Мөн тодорхой түвшний бодлого боловсруулагчид, бизнесийн салбарынханд сургалт явуулах зорилготой байгуулагдсан. Хүрээлэн маань ажиллаад дөнгөж нэг сар гаруй л болж байна. Одоогоор 7 хүнтэй. Ирэх жилээс нэлээд өргөжих болов уу. Ер нь Монголбанкны Ерөнхийлөгч түүхэн шийдвэр гаргасан гэж үзэж байгаа. Монголбанкны тогтолцоо, бүтцэд эдийн засгийн судалгаа, сургалтын хүрээлэнг байгуулсан нь Монгол Улсын урт хугацааны хөгжлийн замд төв банк гэдэг зүйл өөрөө эдийн засгийн хүчирхэг “тинк танк”, судалгааны цөм болох зорилгоор, алсыг харсан шийдвэр гэж бодож байгаа.

» Эдийн засгийн хөгжилд судалгаа хэр сайн хөшүүрэг болж өгдөг вэ?

-Хамгийн энгийнээр хэлэхэд, цээжний “пангаар” ярихаа болино гэсэн үг. Саяхан болсон эдийн засгийн форум, мөн хэвлэл мэдээлэл, олон нийтийг харж байхад цээжний “пангаар” их л сайхан ярих юм. Ийм байхад энэ улс яаж хөгжих юм. Ер нь энэ улсад юу байна вэ, ямар гараанаас эхэлж, яаж хөгжих вэ гэдэг асуудал бий. Хөгжлийн бодлогын баримт бичгүүд байгаа ч тэдгээр нь тэргүүлэх чиглэлээ тодорхойлоогүй, мөн зорилтод хүрэх арга хэрэгсэл нь ямар байх, энэ чиглэлд ямар судалгаа хэрэгтэй вэ гэдгийг тодорхойлоогүй байдаг. Тэгэхээр Монголбанк бол судалгаа талаасаа Монголд байгаа хамгийн том “тинк танк”. Цаашдаа Монголбанкны Эдийн засгийн судалгааны хүрээлэнгийн судалгаа, шинжилгээг

илүү өргөн хүрээнд хийж, үр дүнг нь бодлого боловсруулагчдад хүргэх, практикт нэвтрүүлэх, ингэснээрээ хөгжлийн бодлогыг тодорхойлох, түүн дотроосоо тэргүүлэх ач холбогдолтой зүйлүүдэд илүү анхаарах, ингэснээрээ бидний институци болон засаглалын чанар сайжрах юм. Орчин үеийн эдийн засгийн хөгжлийн онолуудыг судалсны үндсэн дээр судлаач Д.Ган-Очир, Н.Баяртсайхан нар “Улаанбаатарын зөвшилцлийг санал болгох нь” гэсэн баримт бичгийг гаргаж ирсэн. Тэрний хамгийн эхний чиглэл нь “Институци, засаглалын чанарыг сайжруулах” гэж байгаа. Судалгаа, шинжилгээний ажлын чанар сайжирч, тэр нь бодлого боловсруулагчдын шийдвэр гаргалтад эергээр нөлөөлж, үр дүнд нь Монгол Улсын засаглал, институцийн чанарыг сайжруулах нь Монголбанк болон энэ хүрээлэнгийн зүгээс Монгол Улсын эдийн засгийн хөгжилд оруулах хувь нэмэр болох юм.

» Судалгаа хийж болно, гэхдээ судалгааг олон нийт, төр засгийн түвшинд хүлээн зөвшөөрөх, бодлогод тусгах гэдэг асуудал бий. Бидний саналыг тусгахгүй байна гээд л судлаачид гомдоллодог шүү дээ?

-Энэ бол бас засаглалын л асуудал. Эдийн засгийн форумыг ажиглаж байхад нэг хэсэг хүмүүс төр, хувийн хэвшлийн түншлэлийн асуудлыг ярьж байна. Тэгэхээр аливаа судалгаа, шинжилгээний ажил үр дүнтэйгээр практикт нэвтрэхийн тулд харилцан ойлголцлын гүүр байх ёстой.

Бас диалоги буюу харилцан ярианы механизмууд хэрэгтэй. Тэр нь сургалт, хэлэлцүүлгээр хийгдэж болно. Судалгааны үр дүнг шийдвэр гаргагчдын тархи, зүрхэнд итгэл үнэмшил болохуйц хэлбэрээр өгсний дараа судалгааны үр дүн бодлогын практикт тусгалаа олдог. Монгол Улсад энэ талаар дутагдал бий. Тийм учраас хүмүүс бухимддаг. Нэг талаас судлаач, эрдэмтэд нь бухимддаг. Нөгөө талаас онол, практик хоёр өөр, Монголын хөрсөн дээр буугаагүй судалгаа байна гэх ч юм уу. Гэтэл онол болон практик, ажиглалт дээр суурилсан, мөн практик асуудлыг тусгаад, түүний мөн чанар, шалтгаан, үр дагаврын холбоог сайн гаргасан судалгаа нь бодлогын чанарыг сайжруулж байдаг. Тийм учраас гүүр гэж яриад байгаа юм. Тэгэхээр Эдийн засгийн форум дээр төр хувийн хэвшлийн түншлэл гээд ярьж байна. Тэгвэл төр хувийн хэвшлийн түншлэлийн диалоги механизм нь ямар байх юм бэ гэдэг асуудал бий. Сануулж хэлэх хүнгүй бол сайн засаглал ч ялзарна гэж үг байна. Тийм учраас түрүүн ярьсанчлан “Улаанбаатарын зөвшилцөл”-ийн 8 зарчмын 8 дугаарт “Нийгэмд диалоги үүсгэх тухай” дурдсан. Нийгмийн гишүүд, тэр дотроо бизнес эрхлэгчид, төрийн болон төрийн бус байгууллагууд, ард иргэд бие биенээ ойлгох, хийсэн судалгаа, бодлогын чиглэлээ тайлбарлах механизм, гүүр байх ёстой. Тухайлбал, хууль хийх процессыг маш тодорхой болгож өгсөн шүү дээ. Хууль гаргахын тулд та тэдэн удаагийн хэлэлцүүлэг

зохион байгуулж, саналыг тусгасан байх ёстой гээд. Энэ бол миний хэлээд байгаа гүүрийг үүсгэж байна гэсэн үг. Бүгдээрээ хэлэлцвэл буруугүй гэдэг. Яг энэ талаасаа бол Монголбанк, Үндэсний статистикийн хороо хамгийн идэвхтэй ажиллаж байгаа.

» Та “Улаанбаатарын зөвшилцөл”-ийн 8 зарчмын талаар хэд хэдэн удаа онцоллоо. Тэгэхээр бодлогын суурь зарчим байх шаардлага, ач холбогдлын талаар тайлбарлах уу? Та бас “Улаанбаатарын зөвшилцлийг дэмжих нь” гээд нийтлэл бичиж байсан...?

-Бидний хөгжлийн тухай төсөөлөл их сонин. Бид хөгжил ярихаараа Тавантолгой, Оюутолгойгоо хөдөлгөнө, эсвэл тэнд тийм бүтээн байгуулалт хийнэ гэдэг зүйл л ярьдаг. “Улаанбаатарын зөвшилцөл”-ийн 8 зарчмыг харвал тийм бүтээн байгуулалтыг тэнд хийнэ гэсэн зүйл огт байхгүй. Хамгийн гол нь хуулийн засаглал, институцийн засаглал, түүний чанарт анхаарах хэрэгтэй байна гэсэн. Хоёрдугаарт, эдийн засгийн өсөлт, тэр дундаа өсөлтийн хүртээмж хаана байна вэ. Эдийн засаг өсөөд л байдаг нийгэмд нь баян, ядуугийн зааг ялгаа улам нэмэгдээд байвал өсөлтийн үр нөлөө хэнд хүрч байна вэ гэдэг асуудал. Үүнээс болоод баян ядуугийн хана үүсэх гээд байна. Нийгмийг тогтвортой дундаж давхарга хөтлөөд авч явдаг. Үүний үр дүнд нийгэмд дэвшил өрнөж байдаг. Тийм учраас нийгэмд хэт их зааг ялгаа үүсэх сайн зүйл биш. Сүүлийн 27 жилд дэлхийн эдийн засагт гарсан

шинэ сонгодог онолуудын үзэл баримтлалыг нэгтгэж судлаад, тэрний үндсэн дээр Монголд тохирох хувилбарыг гаргаж ирсэн нь “Улаанбаатарын зөвшилцөл” юм. Яагаад зөвшилцөл гэж нэрлэв гэхээр энэ бол нийгмийн зөвшилцлийг шаардсан зүйл. Өөрөөр хэлбэл, бусдад илүү их хүргэж, ингэсний үндсэн дээр бид хөгжлийн тухай төсөөллөө өөрчлөх асуудал юм. Хуулийн засаглалаа өөрчлөхгүйгээр, институцийн чанараа сайжруулахгүйгээр хөгжихгүй юм байна шүү гэх зэргээр нийт 8 зарчмыг бүх нийтээрээ хүлээн зөвшөөрнө гэсэн үг. Үүнд зориулж би хэдэн сарын өмнө “Улаанбаатарын зөвшилцлийг дэмжих нь” гэж бичиж байсан. “Улаанбаатарын зөвшилцөл” бол зөвхөн хоёр хүний санаа биш юм. Олон улсын байгууллагууд, алдартай эдийн засагчдын маш олон жилийн судалгааны үр дүнд бий болсон зүйл. Өөрөөр хэлбэл, дэлхий цаашаа хөгжихийн тулд ийм зүйлүүдэд анхаарах ёстой гэсэн санаа юм. Энэ маань өөрөө хөгжлийн тухай асуудал. Хөгжил гэхээр өндөр байшинтай, гоё замтай бол мэдээж сайхан. Гэхдээ эцсийн эцэст хөгжил гэдэг бол хүн илүү сайхан амьдрах чадварын л тухай асуудал.

» Жигд хүртээмжтэй өсөлтийг бий болгох талаар улстөрчид, Засгийн газрын түвшинд байнга л ярьдаг. Гэвч төдийлөн хэрэгждэггүй. Жигд хүртээмжтэй өсөлтийг бий олгох гол суурь нь юу байх вэ, хүртээмжтэй өсөлтийг бий болгох гол ажил хаанаас эхлэх ёстой вэ?

-Бид хүртээмжтэй өсөлт гэдгийг

шинэ зүйл гэж бодоод байна. Хүртээмжтэй өсөлтийг яаж хэмжих вэ гээд, маш олон хурал, зөвлөгөөн хийгээд л, хүний хөгжил, сайн засаглалын индикатор гэх ч юм уу. Бид аливаа шинэ зүйлийг гаргаж ирэхээсээ өмнө хуучин зүйлийн яг юу нь болохгүй байна вэ гэдгийг бодох хэрэгтэй. Хөгжлийг зөвхөн ДНБ-ээр хэмжих нь өрөөсгөл юм гэдгийг дэлхий нийт хүлээн зөвшөөрөөд, өөр үзүүлэлтүүдийг гаргаж ирж, судлахыг хичээж байна. Тухайлбал, Аз жаргалын индекс гэх ч юм уу. Тэгэхээр миний бодлоор бид ДНБ-ийхээ өсөлтөд гүн гүнзгий анализ хийж сурах хэрэгтэй. Манай хүрээлэнгийн нэг чиглэл нь энэ байх ёстой гэж бодож байгаа. Энэ бол зүгээр л улиралд нэг удаа зарлаад, жилийн эцэст тэдэн хувьд хүрлээ гэж хэлдэг зүйл биш. ДНБ-ий өсөлтийг бий болгохын тулд ард нь хүмүүс, өрх гэрүүд ажиллаж байдаг. Банк, санхүүгийн сектор, аж ахуйн нэгжүүд, Засгийн газар өөрөө байна. Энэ бүхний судалгааг дотоодын эдийн засгийнхаа өсөлттэй уялдуулж, маш нарийн хийх ёстой. Ялангуяа өрхийн эдийн засаг, өрхийн өрийн асуудал байна. Улсынхаа өрийг бид их ярьдаг. Мэдээж үүнд анхаарах л ёстой. Гэхдээ үүнтэй адилхан өрхийн өрийн асуудал бол эцсийн дүндээ санхүүгийн тогтвортой байдлын асуудал юм. Бид санхүүгийн тогтвортой байдлыг нийлүүлэлт талаас нь их ярьдаг. Арилжааны банкууд, ББСБ-уудын зохистой харьцааны үзүүлэлтүүд гэх ч юм уу. Гэтэл үүний нөгөө талд өрхүүд ямар байна вэ. Зээл авсан, тэр дундаа моргейж,

хэрэглээний зээл авчихсан хүмүүсийн санхүүгийн байдал ямар байна вэ, ямар хүлээлтэй байна вэ гэдгийг бид тогтмол судалдаг байх хэрэгтэй. Өрхүүд буюу хэрэглэгчид дараагийн 3, 6 сард тодорхой асуудлаар яг ямар хүлээлтэй байгааг гаргаж ирэх нь эдийн засгийн маш үнэ цэнэтэй мэдээлэл болдог. Монголбанк өмнө нь энэ талын судалгааг хийж байсан юм билээ. Харамсалтай нь одоогоор зогсчихсон байгаа. Тийм учраас 2019 оноос энэ талын судалгааг улирал бүр, янз бүрийн чиглэлээр маш сайн, өндөр түвшинд хийх ёстой гэж үзэж байгаа. Энэ бүхэн маань эдийн засгийн бодлого, тэр дундаа хүртээмжтэй эдийн засгийн өсөлтийг бий болгоход чухал түлхэц болно. Яагаад гэвэл хүртээмжтэй эдийн засгийн өсөлтийг бий болгоё гэж байгаа бол хүмүүсийн санаа бодлыг мэдэх ёстой.

» Саяхан эдийн засгийн чуулган болж өнгөрлөө. Засгийн газрын зүгээс 3 тулгуурт хөгжлийн бодлого гэдгийг тодорхойлж гаргаж ирлээ. Монголын эдийн засгийн бүтэц тийм, ийм байх ёстой гээд ярьж байна. Гэхдээ эдийн засгийн бүтцээ төрөлжүүлэх асуудлыг жил бүр ярьдаг ч яагаад дорвитой алхам хийдэггүй юм бол?

-Монгол Улс жижиг, нээлттэй эдийн засагтай орон. Онолын хувьд ч нээлттэй, жижиг эдийн засгийн загвараар явахаас өөр аргагүй. Бүхнийг дотроо хийгээд, эдийн засгаа яг тэр чиглэл рүү нь тэгж өөрчилнө гээд хэдэн

их наядаар эхэлсэн төсөл ярих хэрэггүй. Хамгийн том мега төсөл бол хүмүүсийн амьдрал л байхгүй юу. Хүмүүсийн “мини” амьдрал. Тэгэхээр мега төсөл бол миний бодлоор хүмүүсийн “мини” амьдрал гэсэн үг. Өөрөөр хэлбэл, хүмүүст боломжийн тэгш байдлыг бий болгосноор тэд амьдралаа тогтвортой авч явж, орлогоо нэмэгдүүлж, ядуурлаас гардаг. Дундаж давхарга нь нийгмээ авч явж байдаг, хүсэл тэмүүлэлтэй, асар их завгүй, тийм л нийгмийг бид хүсч байгаа. Энэ бол эдийн засгийн хамгийн том бүтцийн өөрчлөлт юм. Жишээлбэл, хөдөө аж ахуй гээд аваад үзье. Хөдөө аж ахуй гэхээр малчид гээд ерөнхий утгаар нь ойлгодог. Гэтэл тэнд нийгэм, эдийн засгийн асар том өөрчлөлт явагдаж байна. Үүнийг тэд ярьсан уу? Тухайлбал, малчдын дунд хөрөнгийн ялгаатай байдал маш их нэмэгдэж байна. Цаашдаа энд зааг ялгаа хэт их гарч болохгүй. Гэтэл төрийн бодлого үүн рүү чиглэж чадаж байна уу. Жил бүр ноосны урамшуулал л өгдөг. Гэтэл тэрнийг илүү олон малтай нь л авна шүү дээ. Малчдын дунд ч бас ядуурал байна. Нийгмийнхээ ядуу хэсгийн зовлонг харж байж, бид дундаж давхаргаа голлосон бүтцийг 2030 онд бий болгоно гээд тогтвортой хөгжлийн зорилтдоо биччихсэн байгаа. Ядуурлыг тэг болгоно гээд биччихсэн байгаа. Гэтэл одоо л Монгол Улсын Засгийн газар ядуурлынхаа асуудлыг анх удаа өөрөө хариуцаж зарлаж байна. Өмнө нь Дэлхийн банкны тогтвортой амьжиргаа ч

юм уу, олон улсын байгууллагууд л Монголын ядууралд илүү их санаа зовдог байсан. Гэтэл өнөөдөр бид цаашид тогтвортой нийгмийг байгуулъя, тогтвортой хөгжилд хүрье гэвэл ядуурлыг хүн төрөлхтөнтэй адилаар тэг болгоё гэдэг зорилтоо биелүүлэх ёстой. Энэ бүхэн маань засаглалын тогтвортой байдал, институцийн чанар, инфляцийг удирдах, ханшийн хүлээлт гээд бүх зүйлд эергээр нөлөөлнө. Бүтцийн хувьд уул уурхайн болон уул уурхайн бус эдийн засаг гээд л ярьдаг. Энэ үнэн. Одоо бол хэт өрөөсгөл байна. Бидний сэтгэлгээ хүртэл тийм өрөөсгөл болчихсон. Яагаад гэвэл нийгмээрээ нүүрс, зэсийн үнэ өсөхөд баярладаг. Гэтэл нийгмээрээ ноолуурын экспорт өсөөд, махны шинэ үйлдвэрлэл хөгжвөл баярлаж байх ёстой шүү дээ. Өөрөөр хэлбэл, манайх шиг өрөөсгөл бүтэцтэй эдийн засагт уул уурхайн бус эдийн засгаа илүү сайн харж, анхаарч байх ёстой. Жижиг, нээлттэй эдийн засаг. Дээр нь хоёр том зах зээлтэй маш ойрхон. Энэ хоёр том зах зээлийн дөнгөж захыг нь мөлжихөд л Монгол Улсын эдийн засаг маш их өөрчлөгдөх боломжтой. Яг үүн рүү чиглэсэн төрийн бодлого бас байхгүй. Уул уурхайн бус экспортыг тэргүүлэх чиглэл болгох нь эдийн засгийн бүтцийг урт хугацаанд нь өөрчлөх хамгийн чухал алхам юм.

Ярилцсанд баярлалаа.



МОНГОЛБАНК
МОНГОЛ УЛСЫН ТӨВ БАНК

МОНГОЛБАНКНЫ “ЭДИЙН ЗАСГИЙН СУДАЛГАА,

СУРГАЛТЫН ХҮРЭЭЛЭН”



**МОНГОЛБАНКНЫ “ЭДИЙН ЗАСГИЙН СУДАЛГАА,
СУРГАЛТЫН ХҮРЭЭЛЭН”-ГИЙН НЭЭЛТЭД МОНГОЛБАНКНЫ
ЕРӨНХИЙЛӨГЧ Н.БАЯРТСАЙХАНЫ ХЭЛСЭН ҮГ**

Та бүхэнд энэ өдрийн мэндийг дэвшүүлье!

Бидний урилгыг хүлээн авч хүрэлцэн ирсэн эрхэм хүндэт зочид, төлөөлөгч Та бүхэнд Монголбанкны нэрийн өмнөөс болон хувиасаа гүн талархал илэрхийлье!

Хүн төрөлхтөн шинжлэх ухаан, технологийн ололтод тулгуурлан хурдацтай хөгжиж, даяаршсан нийгмийг цогцлоон бүтээж байна. Даяаршиж буй энэ нийгэмд хувь хүний шийдвэрээс эхлээд төрийн бодлогын оновчтой шийдвэр гаргалтад мэдээллийн үнэ цэнэ түүн дотроо судалгаа, шинжилгээнд тулгуурласан мэдлэг, мэдээллийн хэрэгцээ, ач холбогдол нэмэгдэж байна.

Мэдээллийн үнэ цэнэд суурилсан даяаршлын эрин үед дэлхийн иргэншил, геополитик, олон улсын харилцаа, засгийн газруудын бодлого болон хувь хүмүүсийн шийдвэр гаргалт зэрэгт томоохон өөрчлөлтүүд гарч байна. Энэ цаг үед иргэдийн сайн сайхан байдал, нийгмийн хөгжил, эдийн засгийн өсөлтийн хэтийн бодлогоо даяаршиж буй шинэ дэлхийн хөгжлийн үйл явцтай нягт уялдуулан тодорхойлох сорилт тулгарч байна. Түүнчлэн дэлхийн хөгжлийн хандлага, геополитик, хөрш орнуудын эдийн засгийн төлөв зэргийг тооцож, хөгжлөө эрчимжүүлэхийн тулд богино, дунд,

урт хугацааны хөгжлийн бодлого, стратегиа судалгаанд суурилан өргөн цар хүрээтэйгээр тодорхойлох хэрэгцээ ч өндөр байна.

Эдийн засгийн судалгааны үндсэн зорилго нь бодлогын шийдвэр гаргахад шаардлагатай суурь зарчим болон эмпирик суурийг гаргаж өгөх явдал билээ. Ялангуяа өнөө цаг үед эдийн засгийн өсөлтийг дунд хугацаанд тогтвортой хадгалах, өсөлтийг хүртээмжтэй болгох, цаашлаад гадаад зах зээлийн өөрчлөлтөөс дархлаатай, өөрөө өөрийгөө тэтгэдэг эдийн засгийн тогтвортой хөгжлийг бий болгох асуудал чухал байна.

Манай оронд эдийн засгийн судалгаа, шинжилгээний байгууллагууд мэр сэр байгаа боловч эдийн засгийн урт хугацааны хөгжилд шийдэл гаргаж дуу хоолойгоо өргөсөн, төрийн бодлогод тусгалаа олохуйц тулхтай судалгааг цаг үеийн нөхцөл байдалтай уялдуулан тогтмол хийдэг судалгааны хүрээлэн үндсэндээ алга байна. Эдийн засгийн мэргэжил, эрдмийн зэрэг олгох сургалтууд явагдаж буй хэдий ч санхүүгийн салбарын ажилтнууд, эдийн засагчдыг өндөр түвшинд мэргэшүүлэх, сүүлийн үеийн аргачлал, мэдээллээр хангах дэлхийн түвшний сургалтууд дутмаг хэвээр

байна. Даяаршиж буй нийгэмд бид дэлхийн түвшний мэдлэг, мэдээлэлтэй байж, төрийн бодлогын жолоог зөв зүгт залах учиртай.

Олон улсын туршлагыг харахад эдийн засгийн хөгжлийн бодлогыг нарийн сайн боловсруулахад эдийн засгийн судалгааны хүрээлэнгүүдийн гүйцэтгэсэн үүрэг өндөр юм. Тухайлбал, Солонгос улс Эдийн засгийн хөгжлийн хоёр дахь таван жилийн төлөвлөгөөг 1966 онд батлахдаа “эдийн засгийн судалгааны институцийг маш яаралтай байгуулах” гэж тусгасны дагуу Солонгосын хөгжлийн хүрээлэн (Korean Development Institute)-р 1972 онд “Төрийн хөгжлийн бодлогуудыг боловсруулж, хэрэгжүүлэхэд шаардлагатай байгаа эдийн засгийн суурь асуудлууд дээр судалгаа, шинжилгээ хийх, үндэсний хэмжээний эдийн засгийн түүвэр судалгаа хийх болон бусад улсын туршлагыг судлах” чиг үүрэгтэйгээр үүсгэн байгуулж байв. Анх бүгд докторын зэрэг хамгаалсан 13 шилдэг залуу судлаачтайгаар үйл ажиллагааг эхлүүлж байжээ.

Бусад орны төв банкууд болон олон улсын санхүүгийн байгууллагууд судалгаа, сургалтын хүрээлэнг байгуулан олон улсыг хамарсан үйл ажиллагаа явуулж байна. Эдгээр нь боловсролын зэрэг олгох сургалтаар олгогддоггүй, нарийн мэргэшүүлэх практик суурьтай сургалтуудад илүүтэй анхаарч байна.

Эдгээр хэрэгцээ шаардлага, олон улсын туршлагыг харгалзан үзсэний үндсэн дээр миний бие Монголбанкны хүний нөөц, санхүүгийн боломжид тулгуурлан “Эдийн Засгийн Судалгаа, Сургалтын Хүрээлэн”-г үүсгэн байгуулах санаачилга гарган, Монголбанкны захирлуудын зөвлөлөөс дэмжсэний дагуу өнөөдөр энэ хүрээлэн үүд хаалгаа нээж байна. Миний хувьд хүрээлэнг нэр төдий байгуулах бус, харин төрийн хөгжлийн бодлого боловсруулалт, хэрэгжилтэд шаардлагатай санал зөвлөмжийг судалгаа, шинжилгээнд суурилан бэлтгэдэг үндэсний хэмжээний хүрээлэнгийн шавыг тавьж байна гэж харж байна. Энэ агуулгаар өнөөдөр бол түүхэнд үлдэх онцгой өдөр юм.

Энэхүү хүрээлэнгийн үндсэн зорилго нь үндэсний хэмжээнд эдийн засгийн бодлого боловсруулах, бодлогын оновчтой шийдвэр гаргалтад дэмжлэг үзүүлэх өргөн цар хүрээтэй, даацтай эдийн засгийн бодлогын болон суурь судалгааны ажлуудыг чанарын өндөр түвшинд гүйцэтгэх; мөн төрийн албан хаагчид болон

санхүүгийн салбарын мэргэжилтнүүдэд зориулсан дунд болон ахисан түвшний сургалт явуулах чиг үүргийг хэрэгжүүлэх явдал юм. Энэ жилийн хувьд Хүрээлэнг 7 судлаач, эрдэм шинжилгээний ажилтны бүрэлдэхүүн (1 захирал, 2 ахлах судлаач, 4 судлаач)-тэй байгуулж байна. Цаашид хүрээлэнгийн үйл ажиллагаа өргөжихийн хэрээр санхүүжилт, боловсон хүчний тоог нэмэгдүүлэх боломжтой гэж тооцож байна.

Энэхүү “Эдийн Засгийн Судалгаа, Сургалтын Хүрээлэн”-гийн үйл ажиллагааг тогтвортой хангаж, олон улсын жишигт нийцүүлэн хөгжүүлэх их үйлсэд тус хүрээлэнгийн анхны захирал, судлаачид, эрдэм шинжилгээний ажилтнууд Та бүхний үүрэг онцгой чухал болохыг энд онцгойлон захиж хэлэхийг хүсч байна. Та бидний ажил үйлс түүхэнд үлдэх тул бүгд хичээн ажиллацгаая.

Төрийн болон хувийн хэвшлийн холбогдох байгууллагуудтай нягт хамтран ажиллахыг захихаас гадна хүрээлэнгийн үйл ажиллагаанд дараах хоёр асуудлыг анхаарч ажиллахыг хүсч байна.

Нэгдүгээрт, эдийн засгийн бүтцийн бодлого, салбарын судалгааны ажилд түлхүү анхаарч, Улсын Их Хурал, Засгийн газар, Санхүүгийн тогтвортой байдлын зөвлөлийн гишүүн байгууллагуудад бодлогын зөвлөмж хүргүүлж эхлэх нь чухал байна. Тухайлбал, төрийн бодлогын өмнө хариултаа нэхэж буй маш олон асуудлыг цогцоор судалж, оновчтой шийдлийг гаргахад дэмжлэг үзүүлэх зорилгоор ойрын үед дараах чиглэлд анхаарч ажиллах нь зүйтэй байна:

- Салбарууд дээр баримталж буй бодлогууд болон үндэсний хөгжлийн бодлогын уялдаа, холбоонд үнэлгээ хийж, зөвлөмж гаргах,
- Нийгэм, эдийн засгийн хөгжүүлэх урт хугацааны үндсэн чиглэлд анхаарах асуудлуудыг тодорхойлох,
- Геополитикийн эрсдэлийн дотоод эдийн засагт бий болгох нөлөөллийн үнэлгээг тогтмол давтамжтай хийх,
- Нийгмийн тогтвортой байдал, тогтвортой хөгжилд дэмжлэг үзүүлэхүйц тэтгэврийн системийг бий болгох арга замыг эрэлхийлэх,
- Нийгмийн хамгааллын одоогийн системд цогц үнэлгээ хийж, санал боловсруулах,

- Эдийн засгийн салбаруудын статистик мэдээллийн санг бүрдүүлэх, энэ чиглэлээр бусад холбогдох байгууллагуудтай хамтран ажиллах,
- Салбаруудад тулгарч буй хүндрэл, шийдвэрлэх арга замыг тодорхойлох, зах зээлийн дэд бүтцийг хэрхэн сайжруулах зөвлөмж гаргах,
- Экспортыг төрөлжүүлэх чиглэлд хөдөө аж ахуй, аялал жуулчлал болон үйлчилгээний бусад салбарын судалгааг гүнзгийрүүлэх, гадаад зах зээлд нэвтрэх арга хэлбэрийг тодорхойлох,
- Салбарууд дээрх төрийн оролцоог оновчтой болгох зөвлөмж боловсруулах, төрийн өмчит аж ахуйн нэгжүүдийн удирдлагыг сайжруулахад зөвлөмж гаргах,
- Макроэдийн засгийн бодлого, санхүүгийн бодлого, өрсөлдөөний бодлого, хүний нөөцийн хөгжлийн бодлого, аж үйлдвэр болон үйлчилгээний эдийн засаг, төрийн санхүү, нийгмийн бодлогод түлхүү анхаарч, дараах судалгааны ажлуудыг тэргүүн ээлжинд анхаарч гүйцэтгэхийг санал болгож байна:
 - Эдийн засгийн хөгжилд засгийн газар, бизнес болон аж ахуй эрхлэгчийн гүйцэтгэх үүрэг
 - Эдийн засгийн нийт болон салбаруудын бүтээмж, тэдгээрийг нэмэгдүүлэх боломж
 - Санхүүгийн зах зээлийн хөгжил, тулгамдаж буй асуудлууд
 - Эдийн засгийн болон худалдааны өрсөлдөх чадварыг дэмжих бодлогын болон эрх зүйн орчныг бүрдүүлэх
 - Хотжилтод тулгарч буй асуудлууд, шийдвэрлэх арга зам
 - Гадаад сектор болон тусламжийн Монгол Улсын хөгжилд гүйцэтгэх үүрэг
 - Орон нутгийн хөгжил, тулгамдаж буй асуудлууд
 - Эдийн засгийн хөгжил, хүн амын бодлого болон хүн амзүйн өөрчлөлт, бодлогын түвшинд анхаарах асуудлууд
 - Эдийн засгийн өсөлтийн эх сурвалж, бүтцийн

өөрчлөлт

- Эдийн засгийн хямралаас зайлсхийх, бүтцийн шинэчлэлтийг дэмжих цогц арга хэмжээний төлөвлөгөөний талаарх олон улсын туршлагыг судлах
- Төсвийн тогтвортой байдал, төсвийн секторын шинэчлэлд үнэлгээ хийх зэрэг болно.

Хоёрдугаарт, хийсэн судалгааны үр дүнг банкны салбарын судлаач, мэргэжилтнүүдийн дунд хэлэлцүүлж, бодлогын зөвлөмж гарган нийтэд түгээх, төрийн албан хаагчид болон санхүүгийн салбарын мэргэжилтнүүдийг мэргэшүүлэх сургалтыг хөтөлбөр гарган тогтмол хийж хэвших нь зүйтэй байна. Тухайлбал, дараах чиглэлд анхаарч ажиллах ёстой:

- Олон улсын санхүүгийн байгууллага, бусад орны төв банкуудын сургалтын төвүүдтэй гадаад хамтын ажиллагааг бэхжүүлж, хамтарсан сургалтуудыг өөрийн оронд зохион байгуулах, бусад орны төлөөлөгчдийг урьж оролцуулах,
- Дотоод (Монголбанк, их дээд сургуулиуд болон төрийн байгууллагууд) боловсон хүчинд тулгуурлан эдийн засгийн чиглэлийн дунд болон ахисан түвшний мэргэшүүлэх сургалтын хөтөлбөрийг эрэлт, хэрэгцээнд тулгуурлан боловсруулж, хэрэгжүүлэх,
- Монголбанкны бусад нэгжүүдтэй хамтран жилд 1-2 өндөр хэмжээний бодлогын форум зохион байгуулах, мөн олон нийтийн төрийн бодлого болон эдийн засгийн мэдлэг, мэдээллийг дээшлүүлэх сургалт, семинарыг тогтмол зохион байгуулах зэрэг болно.

Эдийн засгийн судалгаа, сургалтын хүрээлэнгийн үйл ажиллагаа өргөжин тэлж, Монголын тэргүүлэх Тинк Танк болохын зэрэгцээ олон улсын эрдэм шинжилгээний хүрээлэнгийн жишигт хүрч хөгжинө гэдэгт би хувьдаа итгэл төгс байна. Өөрийн эхлүүлсэн санаачилгыг эрийн цээнд хүрч, тавьсан том зорилтдоо хүрэхэд миний хувьд бүх талаар дэмжин, хамтран ажиллах болно.

Та бүхэнд баярлалаа!

МОНГОЛБАНК

Улаанбаатар, 2018 оны 5 дугаар сарын 1

Мөнгөний бодлогын хороо

1. Мөнгөний бодлогын хороо 7 гишүүнтэй байх бөгөөд Монголбанкны Ерөнхийлөгч, Тэргүүн Дэд Ерөнхийлөгч, Дэд Ерөнхийлөгч болон УИХ-ын Эдийн засгийн байнгын хороо нэр дэвшүүлж, УИХ-аас 6 жилийн хугацаатай томилогдсон орон тооны бус 4 гишүүнээс бүрдэнэ.

2. Мөнгөний бодлогын хороо дараах асуудлыг хэлэлцэж, шийдвэрлэнэ.

- Төрийн мөнгөний бодлогын төсөл

- Мөнгөний бодлогын хэрэгслийн хүүг тогтоох

- Банкны заавал байлгах нөөцийн хэмжээ, зохистой харьцааны шалгуур үзүүлэлтүүдийн хувь хэмжээг тогтоох

3. Мөнгөний бодлогын хороо хуралдаанд оролцсон гишүүдийн олонхийн саналаар шийдвэр гаргах бөгөөд санал тэнцсэн тохиолдолд хуралдаан даргалагчийн саналаар шийдвэрлэнэ.

4. Мөнгөний бодлогын хороо жилд 4-өөс доошгүй удаа хуралдана. Монголбанкны Ерөнхийлөгч эсхүл хорооны 3-аас доошгүй гишүүн санал гаргасан бөл ээлжит бус хуралдааныг зарлан хуралдуулна.

5. Мөнгөний бодлогын хорооны шийдвэр нь тогтоол хэлбэртэй байх бөгөөд түүнд хуралдаан даргалагч гарын үсэг зурж, баталгаажуулна.

Төв банк /Монголбанк/-ны тухай хуулийн
27.3 дугаар зүйлээс...



МОНГОЛБАНКНЫ
ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ТУШААЛ

Мөнгөний бодлогын
хорооны 2018 оны
хуралдааны тов

- 2018.06.18-22
- 2018.09.17-21
- 2018.12.17-21

МӨНГӨНИЙ БОДЛОГЫН ХОРООНЫ ГИШҮҮД



Н.БАЯРТСАЙХАН
(Монголбанкны Ерөнхийлөгч)



О.ЭРДЭМБИЛЭГ
(Монголбанкны Тэргүүн Дэд Ерөнхийлөгч)



Б.ЛХАГВАСҮРЭН
(Монголбанкны Дэд Ерөнхийлөгч)



Ч.ХАШЧУЛУУН
(Эдийн засгийн ухааны доктор)



Ц.БАТСҮХ
(Эдийн засгийн ухааны доктор)



Ц.МӨНХБАЯР
(Эдийн засгийн ухааны магистр)

МӨНГӨНИЙ БОДЛОГЫГ ХАМТЫН ЗАРЧМААР ГАРГАХ НЬ

Хамтын зарчмын давуу талууд

2004 он гэхэд дэлхийн 80 орчим төв банк мөнгөний бодлогын шийдвэрээ аль хэдийн хороогоор хэлэлцэж гаргадаг байсан¹ бөгөөд түүнээс хойш хамтын зарчмаар шийдвэр гаргах энэхүү чиг хандлага олон улсад эрчимжсээр байна. Зах зээлд оролцогчдын хүлээлт, хариу үйлдэл өөрчлөгдөхийн зэрэгцээ эдийн засгийн бүтэц тасралтгүй өөрчлөгддөг тул загварын үр дүнгээс гадна мэдлэг, туршлагатай экспертүүдийн үнэлэлт, дүгнэлт нь шийдвэр гаргах процессийн зайлшгүй хэсэг болдог. Мөнгөний бодлогын шийдвэрийг хороогоор гаргах нь дараах давуу талуудыг бий болгодог²:

- **Мэдээлэл цуглуулалт:** Хорооны гишүүдээр дамжин олон төрлийн эх үүсвэрээс мэдлэг, мэдээлэл нэг дор цугларах боломжтой тул илүү мэдээлэлтэй шийдвэр гарах боломжийг нэмэгдүүлдэг. Мөнгөний бодлогын хорооны хурлын үеэр тодорхой нэг чиглэлээр (макро эдийн засаг, мөнгөний бодлого, эконометрикийн загвар, санхүүгийн зах зээл, улсын эдийн засгийн аль нэг нэг гол сектор, улсын төсөв г.м.) онолын

мэдлэг болон практик туршлагатай гишүүд хоорондоо мэдлэг, мэдээллээ хуваалцах нь эдийн засгийн нөхцөл байдлыг илүү олон талаас, бодитоор дүгнэх боломжийг нэмэгдүүлдэг.

- **Мэдээлэл боловсруулалт:** Шинжилгээ, дүгнэлт хийх олон төрлийн арга барилтай гишүүд нэг дор цугларах нь харилцан сул талаа нөхөж, шийдвэр гаргах процессийг илүү үр ашигтай болгох боломжтой тул нэг хүн дангаараа шийдвэр гаргах тохиолдолтой харьцуулахад хорооны шийдвэр давуу талтай гэж үздэг.
- **Хэт нэг тийш хэвийсэн шийдвэр гарах эрсдэлийг бууруулдаг.** Олон төрлийн үзэл бодол, өнцгөөс хэлэлцүүлэг өрнүүлж, санал хураалтаар эцсийн шийдвэрийг гаргах нь хэт туйлширсан шийдвэрээс сэргийлэх чухал нөхцөл болдог. Түүнчлэн, хорооны шийдвэр нь харилцан урвуу хамааралтай зүйл эсхүл үр дүн нь хоорондоо сөргөлдөх бодлогын сонголт дээр дундын оновчтой хувилбараар шийдэлд хүрэх боломжийг дээшлүүлдэг.

Мөнгөний бодлогын хорооны оновчтой бүтэц

Мөнгөний бодлогын шийдвэрийг хамтын зарчмаар

¹ Pollard (2004)

² Blinder (2006)

гаргах явдал нь олон улсын жишиг болсон ч, тухайн улс орныхоо онцлогоос хамаараад төв банкны мөнгөний бодлогын хороо нь бүтэц бүрэлдэхүүн, хурлын дэг, шийдвэр гаргах зарчмын хувьд харилцан адилгүй байна. Мөнгөний бодлогын хороогоор шийдвэр гаргах үеийн давуу болон сул талуудыг судалсны үндсэн дээр дараах шинж чанартай хороог Maier (2010) оновчтой гэж тодорхойлжээ.

Оновчтой мөнгөний бодлогын хорооны шинж чанарууд

1.Зорилгын тодорхой байдал, хараат бус байдал

Мөнгөний бодлогын зорилго тодорхой байх, үр дүнтэй арга хэрэгслүүдтэй байх

Төв банкны хараат бус байдлын индекс өндөр байх

2.Мөнгөний бодлогын хорооны хэмжээ

Гишүүний тоо 5-аас хэт олон биш

Гишүүдийн тоо хэт олон байх нь мэдээлэл солилцох, шийдвэр гарах процессийг удаашруулдаг. Энэ нөхцөлд саналын эрхгүй гишүүдийг оролцуулах нь үр дүнтэй.

3.Гишүүн бүр хувь нэмрээ оруулдаг байх

Гишүүн тус бүрийн оролцоо, хувь нэмрийг үнэлэх боломжтой байх

4. Гишүүдийн эсрэг тэсрэг байр суурь, эсвэл бие биенээ аялдан дагах үзэгдэл хорооны үйл ажиллагаанд сөрөг нөлөөтэй

Гишүүдийг дор бүрээ сэтгэх, өөрийн бодолтой байхыг дэмжих

Олон төрлийн мэдлэг, туршлагатай гишүүдийг цуглуулах

Төв банкны дотроос болон гаднаас томилогдсон гишүүдтэй байх

Хурлын үед ярих тодорхой дараалалгүй байх

Тус судалгаанд тодорхойлсон оновчтой мөнгөний бодлогын хорооны гол гол онцлогийг дэлгэрүүлж тайлбарлавал:

- Мөнгөний бодлогын хорооны гаргаж буй шийдвэр үр дүнтэй байх эсэх нь төв банкны зорилго тодорхой эсэх, тэрхүү зорилгоо биелүүлэх хараат бус байдал нь хэр хангагдсан зэрэгтэй шууд холбогддог. Дэлхийн ихэнх төв банкууд үндсэн зорилгоо “үнийн тогтвортой байдал” хэмээн тодорхойлох чиг хандлага 1990-ээд оноос эрчимжсэн бөгөөд, 2000 онд 94 орны

төв банкнийг оролцуулсан судалгаанд 85 төв банк зорилгоо ийнхүү томъёолсон байв.³ Тэр дундаас төв банкны хараат бус байдлын индекс болон ил тод байдлын индексээр өндөр үзүүлэлттэй төв банкуудтай орнуудад инфляцийг нам бөгөөд тогтвортой байлгах зорилт илүү амжилттай биелсэн байдаг⁴.

- Бүрэлдэхүүний хувьд, санал асуулгаар дэлхийн 55 оронд төв банкны мөнгөний бодлогын хороо нь 5-10 гишүүнтэй байсан бол ердөө 8 төв банк л 10-аас олон гишүүнтэй байв. Зөвлөлийн гишүүд нь төв банкны экспертүүдээс гадна, академик судлаач, зарим тохиолдолд бизнесийн болон засгийн газрын яамдын төлөөлөл байх нь түгээмэл байна. Гишүүдийн тоо хэт олон үед мэдээлэл цугларах, олон өнцгөөс асуудалд хандах зэрэг зөвлөлөөр шийдвэр гаргахын гол давуу талууд алдагдаж, шийдвэр гаргалтын хурд удааширдаг эрсдэлтэй. Иймд Холбооны нөөцийн банк, Европын төв банк зэрэг зарим төв банкууд мөнгөний бодлогын хуралд зарим оролоцогчдыг саналын эрхгүй оролцох боломжийг нээлттэй үлдээдэг. Ингэснээр зөвлөл шийдвэрт хурдан хүрэх боломжийг хязгаарлахгүйгээр, олон төрлийн мэдээлэл цугларах боломжийг нээлттэй үлдээдэг.
- Аль нэг гишүүн нь бусаддаа найдах, өөрийн хувь нэмрийг оруулахгүй (free riding) байх нь багаар ажиллах үед түгээмэл ажиглагддаг нь сорилт болдог. Мөнгөний бодлогын хорооны үйл ажиллагаанд энэхүү эрсдэлийг хаахын тулд гишүүдийн оролцоо, гүйцэтгэж буй ажил үүргийн үнэлгээг тодорхой болгох шаардлагатай. Мөн гишүүд бие биенийхээ үзэл бодлыг аялдан дагах, эсхүл хоорондоо хэтэрхий өөр байр суурин дээр зогсохгүй байх, эдийн засгийн байдлыг олон өнцгөөс дүгнэх өргөн хүрээний мэдлэг чадвар, туршлагатай байх нь зөвлөлийн үйл ажиллагаагаа үр дүнтэй явагдахад түлхэц болно.

³ Mahadeva and Sterne (2000)

⁴ Dincer and Eichengreer (2014), Cukierman (2006)

УЛААНБААТАРЫН ЗӨВШИЛЦӨЛ: ТӨСВИЙН САХИЛГЫГ ХАНГАХ, ҮНДЭСНИЙ ХУРИМТЛАЛТАЙ БОЛЖ, ТУУШТАЙ НЭМЭГДҮҮЛЭХ, БОДИТ ЭДИЙН ЗАСАГ, ИНФЛЯЦЫГ ТОГТВОРЖУУЛАХ

Монгол Улсын эдийн засгийн өсөлт сүүлийн жилүүдэд удааширч төсөв, төлбөрийн тэнцэлд алдагдал үүссэн бөгөөд ирж буй онуудад бондын эргэн төлөлтүүд хийгдэхээр байна. Гадаад, дотоод эдийн засгийн хүндрэлтэй нөхцөл байдал, уул уурхайн хэт хамаарал, төсвийн сахилга бат, нэгдмэл байдал хангалтгүйгээс төсвийн алдагдал ихээхэн хэмжээгээр нэмэгдэж, үүнийг дагаад өндөр хүүтэй үнэт цаас гаргах замаар төсвийн алдагдлыг санхүүжүүлж байсан зэрэг нь Засгийн газрын өрийн хэмжээг огцом нэмэгдүүлж, хүүгийн төлбөрийн дарамтыг өсгөснөөр төсвийн тэнцвэргүй байдлыг бий болгоод байна.

Монгол Улсын Засгийн газрын нийт өрийн үлдэгдэл 2017 оны жилийн эцсийн байдлаар 22.7 их наяд төгрөг болж өнөөгийн үнэ цэнээр

дотоодын нийт бүтээгдэхүүний 74.4 хувьтай тэнцэж байна. Үүний 18.6 хувийг дотоод өр, 74.1 хувийг гадаад өр, 7.3 хувийг өрийн баталгаа эзэлж байна.

Үүсээд байгаа хүндрэлийг даван туулж макро эдийн засгийг тогтворжуулах, цаашид дунд хугацаанд өсөлтийг хангахын тулд Олон Улсын Валютын Сантай хамтран “Extended Fund Facility” буюу “Өргөтгөсөн санхүүжилтийн хөтөлбөр”-ийг хэрэгжүүлж байна. Энэ хөтөлбөр нь бүтцийн алдаанаас хамаарч эдийн засгийн өсөлт саарсан, төлбөрийн тэнцэл ихээхэн хүндрэлтэй байгаа улс, орнуудад зориулагдсан бөгөөд урт хугацаанд өргөн хүрээний арга хэмжээг хэрэгжүүлэх боломж бүрдүүлдгээрээ онцлог юм.

ОУВС-тай хамтран хэрэгжүүлэх “Өргөтгөсөн санхүүжилтийн хөтөлбөр” нь 3 жилийн хугацаатай

энэ хүрээнд ОУВС-аас 440 сая ам.долларын санхүүжилтийг олгох бөгөөд ОУВС, олон улсын байгууллагууд хандивлагч орнуудаас нийтдээ 5.5 орчим тэрбум ам.долларын хөнгөлөлттэй санхүүжилтийг төсвийн алдагдал, төлбөрийн тэнцлийн зориулалтаар авч ашиглана.

Энэ хөтөлбөр хэрэгжсэнээр валютын нөөц нэмэгдэж, ханшийн дарамт буурдаг. Төсвийн алдагдлыг хөтөлбөрийн хүрээнд бусад донор орон, байгууллагатай ярьж санхүүжүүлдэг. Жишээ нь Дэлхийн банк, Азийн хөгжлийн банк, Жайка гэх мэт ОУВС-гаас бусад санхүүгийн байгууллага, донор орнуудаас төсвийн орлогод дэмжлэг үзүүлдэг.

Төлбөрийн тэнцлийг сайжруулан макро эдийн засгийн тэнцвэрийг хангаж, дунд хугацаанд өрийн дарамтыг бууруулах, эдийн засгийн бүтцийг төрөлжүүлж, түүхий эдийн



үнээс хэт хамааралтай байдлыг өөрчлөх, бизнесийн таатай орчин бүрдүүлэх зэрэг бодлого хэрэгжүүлснээр, дунд хугацаанд эдийн засгийн өсөлт нэмэгдэж ойролцоогоор 8 хувь, инфляцийн түвшин ойролцоогоор 6-7 хувь болно.

Төсвийн нэгдмэл байдлыг хангах, сахилгыг чангатгах, төсвийн тогтвортой орлогын эх үүсвэрийг бий болгох, төсвийн зарлагын үр ашгийг сайжруулах замаар дунд болон урт хугацаанд төсвийн алдагдлыг үе шаттайгаар бууруулж, төсвийн тогтвортой байдлыг хангах.

Төсвийн орлогын тогтвортой эх үүсвэрийг бий болгох бүхий л боломжийг дайчлах үүднээс хадгаламжийн хүүгийн орлогод татвар ногдуулах, хувь хүний орлогын албан татварыг

шатлалтай болгох, зарим бараа бүтээгдэхүүний онцгой албан татварыг нэмэх, импортын тамхинд ногдох гаалийн албан татварыг нэмэх зэрэг бодлогын арга хэмжээг авч хэрэгжүүлж байна.

Төсвийн зарлагыг үе шаттай бууруулах хүрээнд нийгмийн хамгаалал, халамжийг хавтгайруулахгүй буюу хүн амын орлого багатай эмзэг хэсэгт түлхүү чиглүүлэх, хүн ам зүйн бүтэц болон хууль эрх зүйн орчны өөрчлөлтийн улмаас төсөвт үүсэх зардлын ачааллыг бууруулах, тэтгэврийн тогтолцоог шинэчлэх, цалин хөлсийг эдийн засгийн бодит өсөлт, орлогын боломжоос түрүүлж нэмэгдүүлэхгүй байх, удирдлагын зардлыг царцаах, үр ашгийг нэмэгдүүлэх зарчмыг баримтлан холбогдох арга хэмжээг үе шаттай

авч хэрэгжүүлэх.

Өрийн тогтвортой байдлыг хангах хүрээнд төсвийн алдагдлыг үе шаттай бууруулж, урт хугацаатай, хүү багатай гадаад зээлийн санхүүжилтийг түлхүү ашиглах замаар богино хугацаатай өндөр хүү бүхий дотоод үнэт цаас гаргалтын хэмжээг бууруулж, төсөв дэх хүүгийн зардлыг багасган, төсөвт учруулах төлбөрийн дарамтыг жигдлэх бодлого баримтална.

Инфляцийг нам, тогтвортой түвшинд хадгалах мөнгөний бодлогыг хэрэгжүүлэх, Төв банкны засаглалыг сайжруулах, валютын ханш макро эдийн засгийн суурь хүчин зүйлстэй нийцтэй уян хатан тогтох, төсвийн шинж чанартай хөтөлбөр хэрэгжүүлэхгүй байх зэрэг бодлогын арга хэмжээ авах зэргээр үр дүнгээ өгнө.

МОНГОЛБАНКНЫ ЭРДЭНЭСИЙН САНГААС

АЛТ ШАРМАЛ ДОМБО

XIX - XX зууны сүүл

Жин: 728 гр

1. Таггүй домбо: жин 363 гр, 18 х 7 см

2. Тагтай домбо: жин 365 гр, 18 х 7 см

1987 онд Улаанбаатар хотын Октябрийн районы 28 А байрны 40 тоотын оршин суугч Шаравын Дэнцоогоос Эрдэнэсийн санд худалдан авчээ.

ЛУУН ХЭЭТЭЙ АЛТ ШАРМАЛ ХОС ДОМБО. Амсар, ёроол болон бүслүүрийг цогт чандмань эрдэнийг хөөцөлдөн буй хос луугаар хээлэн чимэглэсэн бөгөөд бариул, бүслүүр, омог ёроолыг алтаар шарсан. Мөн домбоны бариулыг луугаар үйлдэн, омогт таван саварт лууг хөөмөлдөн чимэглэжээ.



МОНГОЛБАНК

Монголбанк юу хийдэг вэ?

■ Төв банк/Монголбанк/-ны тухай хуульд зааснаар ■
өөрийн зорилтыг биелүүлэхийн тулд дараах
чиглэлээр үйл ажиллагаа эрхэлнэ.

Мөнгөний бодлого боловсруулж, хэрэгжүүлэх



Монголбанк төрийн мөнгөний борлогыг
боловсруулж, хэрэгжүүлнэ.



Монголбанк дараагийн жилд баримтлах төрийн
мөнгөний бодлогыг боловсруулж, жил бүрийн 10
дугаар сарын 1-ний дотор Үндсэн Их Хуралд өргөн
барина.



Мөнгөн тэмдэгт гүйлгээнд гаргах, зохицуулах



Мөнгөн тэмдэгт гүйлгээгээрэх, тээвэрлэх,
хадгалах, түүнийг нөөцлөхтэй бай болгох, түүний төгсгөлд
эсэхийг тодорхойлох, гэмтэл, нууцданыг олох, устгах
эсэхийг эрхлэн зохион байгуулна.



Гэмтэл, нууцданыг мөнгөн тэмдэгт олох журмыг
Монголбанк тогтооно.

Засгийн газрын санхүүгийн зуучлагчийн үүрэг гүйцэтгэх



Төрийн санхүүгийн нэгдсэн дансыг Санхүүгийн сайрын
тусалтаар өөр дээрээ байрлуулж, гүйцэтгэх эрхэлнэ.



Засгийн газрын тусалтаар Засгийн газрын үйл
цэврийг бусад этгээдэд зуучлах борлуулна.



Хууль тогтоомжид нийцсэн зуучлалын бусад үйл
ажиллагаа эрхэлнэ.



Банк болон хуульд тусгайлан заасан этгээдийн үйл ажиллагаанд хяналт тавих



Банкны тогтоомжонд нийцдэггүй байдлыг бэлгүүрэн
зорилгоор банк байгуулах зохионол банканд олоно.



Үйл ажиллагааг нь зохицуулалттай зохиогдож дараа,
журмыг өндөр гаргах, хэрэгжлэлтэд нь хяналт тавина.



Хадгаламжийн даатгалын корпорацийн үйл
ажиллагаанд хяналт тавина.

Үндэсний төлбөрийн систем, түүний үйл ажиллагааг удирдан зохион байгуулах



Банк хоорондын төлбөр тооцоог Монголбанкна дахь
тухайн Банкны харилцааг дансаар дамжуулан
гүйцэтгэнэ.



Үндэсний төлбөрийн систем, түүний үйл
ажиллагаанд зохиогдож харилцааг Үндэсний
төлбөрийн системийн тусгай зурванд зохиуулна.



Гаднад валютын улсын нөөцийг эзэмших, удирдах



Монголбанк эзэмших, удирдаж байгаа гаднад
валютын улсын нөөцийг гаднад төлбөрийг турши
гүйцэтгэх чадвар, нийцдэггүй байдлыг зохино.



Монголбанк чөлөөтэй харилцааг гаднад валют, түүний
идэвхтэй харилцааг нэгдсэн зурванд, хадгалах
ашигтай нэгдлийн тогтоомжонд байдал зохино.

Банкны харилцаагч, хадгаламж эзэмшигчийн эрх ашгийг хамгаалах



Зохистой харилцааг зөвхөөрөө хяналт тавихыг
зорилгоор хамгаалах зохионтой зохиуулна.



Санхүүгийн зорилгоор зохионол "Их 20"-ийн 11
архыг хэрэглэнэ.



Овоо нийтийн санхүүгийн сурь мэдлэгийг
дамжуулах хөдөлгөөнийг зорилгоор.



Макро зохистой бодлого хэрэгжүүлэх



Мөнгөний бодлогыг хэрэгжүүлж болон банк,
санхүүгийн зорилгоор тодорхойлох, үндэсний
санхүүгийн зорилгоор тус бодлогыг боловсруулна.



Макро зохистой бодлогыг зөвхөөрөө байдал өөр
харилцаагаар зохион хэрэгжүүлнэ.



А.ЭНХТҮВШИН **ГАДААД ВАЛЮТЫН УЛСЫН НӨӨЦ ҮНДЭСНИЙ МӨНГӨН ТЭМДЭГТИЙН БАТАЛГАА БОЛДОГ**

“Монголбанк юу хийдэг вэ” булангийнхаа энэ удаагийн зочноор Монголбанкны Нөөцийн удирдлага, санхүүгийн зах зээлийн газрын ахлах эдийн засагч А.Энхтүвшинтэй ярилцлаа. Монголбанкны үйл ажиллагааны нэг чухал хэсэг нь Гадаад валютын улсын нөөцийг удирдаж, зохист түвшинд өсгөхөд чигэлдэг. Тэгвэл Нөөцийн удирдлага, Санхүүгийн зах зээлийн газар, тэр дундаа Гадаад валютын улсын нөөцийн удирдлагын хэлтэс нь төв банкны энэхүү үйл ажиллагааг гардан гүйцэтгэдэг нэгж юм.

ВАЛЮТЫН НӨӨЦ БАЙНГА Л ӨСЧ, БУУРЧ БАЙДАГ. ЭНЭ ХЭЛБЭЛЗЭЛ ЮУНААС ШАЛТГААЛДАГ ВЭ?

ГВУН-ийн түвшний хэлбэлзэлд нөлөөлөх хэд хэдэн хүчин зүйлс бий. Юуны түүрүүнд төлбөрийн тэнцлийн ашиг алдагдал валютын нөөцөд шууд нөлөөлдөг. Төлбөрийн тэнцэл ашигтай гарсан нөхцөлд тэр хэмжээгээр ГВУН өсөж нөгөөтээгүүр алдагдалтай гарсан үед нөөцийн валютаар уг алдагдлыг нөхдөг. Төлбөрийн тэнцэл нь гадаадын шууд хөрөнгө оруулалт, экспорт, манай улсын хувьд экспортын голлох түүхий эдийн үнэ зэргээс түлхүү хамаардаг.

Орлого талаасаа гадаад зээл, донор орнуудын тусламж болон дотоодын зах зээлийн алт худалдан авалт зэрэг нь нөөцийн түвшинг нэмэгдүүлэх гол хүчин зүйл юм. “Ашигт малтмалын тухай хууль”-д 2014 онд нэмэлт, өөрчлөлт оруулснаар алтны үйлдвэрлэл өмнөх онуудтай харьцуулахад эрс нэмэгдсэн. Өнгөрсөн жилүүдийн тоон баримтуудаас дүгнэхэд 2014 онд АМНАТ-ийн хэмжээг бууруулсан нь дотоодын алт олборлолтыг дэмжсэн

чухал шийдвэр болсон. Ингэснээр Монголбанкинд тушаасан алт, улсын төсөвт орох орлогын хэмжээ эрс нэмэгдээд байгааг харж болохоор байна. Монголбанк дотоодын зах зээлээс худалдан авсан алтыг гадаадын алт цэвэршүүлэх үйлдвэрт хүргүүлэн, мөнгөжүүлсний дараагаар тус мөнгөжсөн алтыг ГВУН-ийн удирдлагын хүрээнд ам.долларт болон бусад валютад хөрвүүлэх эсвэл биет болон биет бус алт хэлбэрээр өөрийн гадаад дахь өндөр зэрэглэлтэй банкны дансанд төвлөрүүлж, валютын нөөцийг нэмэгдүүлдэг.

-МОНГОЛБАНКНЫ ГАДААД ВАЛЮТЫН НӨӨЦИЙН АКТИВ ЮУНААС БҮРДЭГ ВЭ, МӨН МӨНГӨЖСӨН АЛТЫГ ХЭРХЭН НӨӨЦИЙН ХҮРЭЭНД УДИРДААГ ВЭ?

-Гадаад валютын улсын нөөц нь дараах үндсэн активын төрлөөс бүрддэг. Үүнд нэгдүгээрт, “Гадаад орны банк, санхүүгийн байгууллагад хадгалж байгаа мөнгөжсөн алт”, хоёрдугаарт, “Бэлэн ба бэлэн бус хэлбэрээр байгаа чөлөөтэй хөрвөдөг гадаад валют”, “Чөлөөтэй хөрвөдөг гадаад валютаар чөлөөтэй төлөгдөх вексель”, “Гадаад орны Засгийн газар, Төв банк, Олон улсын санхүүгийн байгууллагаас гаргасан буюу Баталгаажсан чөлөөтэй хөрвөдөг гадаад валютаар нэрлэсэн, түүгээр төлөгдөх бүх төрлийн үнэт цаас”, “Олон улсын хэмжээнд гадаад валютын нөөцөд тооцогдох бусад актив” багтдаг.

ГВУН-ийг ам.доллар, евро, юань, иен, мөнгөжсөн алт зэрэг гадаад зах зээлд чөлөөтэй хөрвөх боломжтой валютууд голчлон бүрдүүлдэг. Үүнээс алт нь Монголбанкны агуулахад хадгалагдах эсвэл гадаадын

банкны дансанд байршуулснаар аливаа өгөөж олдоггүй. Эсрэгээрээ ханшийн эрсдэлд орох магадлал өндөр байдаг. Тийм болохоор зах зээлийн тохиромжтой нөхцөл бүрдсэн үед мөнгөжсөн алтны тодорхой хувийг бусад валютад хөрвүүлэх замаар ханшийн эрсдэлийг буруулах, бусад валютаар хадгаламж байршуулах замаар өгөөж авах, нөөцийг нэмэгдүүлж ажилладаг. Мөнгөжсөн алтыг бусад валютад хөрвүүлэхдээ алтны багцын хэмжээ нөөцийн жишиг голчоос хэтэрсэн эсэх, мөн алт олборлолтын идэвхтэй улиралд тушаагдах алтны хэмжээ, хүлээлт зэргийг харгалзан үздэг.

-ВАЛЮТЫН НӨӨЦИЙН ЗОХИСТОЙ ТҮВШИНГ ХЭРХЭН ТООЦДОГ ЮМ БОЛ?

-Олон улсад ГВУН-ийн доод хэмжээг тухайн улсын 3 сарын импортын хэрэгцээг хангах түвшин гэж үздэг. Манай улсын хувьд 2018 оны 3 дугаар сарын эцсээр ГВУН 3.0 тэрбум ам.доллартай тэнцэж байгаа

хангах, гадаад өрийн үйлчилгээг гүйцэтгэх, хөрөнгө оруулагчдын манай улсад итгэх итгэлийг бэхжүүлэх зэрэг олон чухал үүргийг агуулдаг. Төв банк валютын ханшийг онилж бодлого явуулдаггүй. Валютын урсгалын тэнцлээс шалтгаалж ханшийн хэлбэлзэл бий болдог. Нөөц нэмэгдэхийн хэрээр дотоодын валютын зах зээл тогтворжиж, улмаар валютын төгрөгтэй харьцах ханш зах зээлийн уян хатан зарчмын дагуу тогтох нөхцөл бүрддэг давуу талтай.

-ЦААШИД ДЭЛХИЙН ЭДИЙН ЗАСГИЙН ХАНДЛАГЫН ТАЛААР ЯМАР ХҮЛЭЭЛТЭЙ БАЙГАА ВЭ? ДЭЛХИЙН ЭДИЙН ЗАСГИЙН ХАНДЛАГА ХЭРХЭН ӨӨРЧЛӨГДӨХ НЬ МОНГОЛД ОРЖ ИРЭХ ВАЛЮТЫН УРСГАЛ, ЦААШЛААД ГАДААД ВАЛЮТЫН НӨӨЦ ӨСӨХ, БУУРАХАД ЧУХАЛ НӨЛӨӨТЭЙ БАЙХ?



М.Болортуяа, Г.Намуун, А.Энхтүвшин, Г.Өсөхбаяр


нь импортын барааны хэрэгцээг 9.3 сарын туршид, импортын бараа болон үйлчилгээний хэрэгцээг 6.6 сарын туршид хангахуйц хэмжээний үзүүлэлт. Гэвч Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалд гадаад валютын нөөцийг улсын импортын нэг жилийн хэрэгцээг хангах хэмжээнээс багагүй түвшинд байлгах аргаар заасан байдаг. Энэ оноос эхлэн нөөцийн хөрөнгө оруулалтын хэрэгслийг төрөлжүүлэн, хүүний нөөцийн чадавхыг нэмэгдүүлж, зөвшөөрөгдсөн эрсдэлийн хязгаарлалтуудын хүрээнд нөөцийн удирдлагын өгөөжийг нэмэгдүүлэх ажлыг амжилттай эхлүүлээд байгаа.

-ВАЛЮТЫН НӨӨЦИЙГ ӨНДӨР ТҮВШИНД БАРИХЫН ГОЛ АЧ ХОЛБОГДОЛ, ЭНЭ НЬ ВАЛЮТЫН ХАНШИД НӨЛӨӨТЭЙ ЮУ?

-ГВУН-нь үндэсний мөнгөн тэмдэгтийн үнэ цэнийн баталгаа болох, хямралын эрсдэл даах чадварыг

-ОУВС-ийн 4 дүгээр сард зарласан шинэчилсэн төсөөллөөр 2018 оны дэлхийн эдийн засгийн өсөлтийн төсөөллийг 3.9 хувьд хэвээр үлдээсэн бол АНУ, Евро бүс зэрэг хөгжиж буй эдийн засгийн өсөлтийг өмнөх төсөөллөөс тус бүр 0.2 хувиар нэмэгдүүлсэн. АНУ-ын төсвийн тэлэх бодлого, евро бүсийн эдийн засагт гарч буй эерэг өөрчлөлтүүдээс шалтгаалан эдийн засгийн өсөлт нь ийнхүү богино хугацаанд нэмэгдэх ч, дунд, урт хугацаанд зарим мөчлөгийн шинж чанартай өөрчлөлтүүд гарснаар эдийн засгийн өсөлт саарах хүлээлттэй байна. Тухайлбал, гарцын зөрүү буурахын хэрээр хөгжингүй орнууд мөнгөний бодлогоо чангатгах, улмаар дэлхийн санхүүгийн зах зээлийн өсөлт саарах; АНУ-ын татварын шинэчлэлийн нөлөөгөөр тус улсын эдийн засгийн өсөлт богино хугацаанд нэмэгдэх ч, дунд хугацаанд төсвийн алдагдлыг бууруулах чиглэлд засварлагдах; БНХАУ-ын зээлийн өсөлт, төсвийн бодлого чангарахын хэрээр тус улсын эдийн засгийн өсөлт удаашрах, эрэлт буурах эрсдэл байсан хэвээр байна.

-ЯРИЛЦСАНД БАЯРАЛААА.



МОНГОЛБАНКНЫ ХЭВЛЭЛИЙН БАГА ХУРЛААС... /2018.05.23/

Монголбанкнаас сар тутам зохион байгуулдаг хэвлэлийн бага хурал энэ сарын 15 болон 23-нд болж, Монголбанкны 2017 оны жилийн тайлан, ашиг алдагдал болон ипотекийн зээлийн санхүүжилтийн асуудлаар дэлгэрэнгүй мэдээлэл өгч, сэтгүүлчдийн сонирхсон асуултад хариуллаа.

NTV телевиз: Сүүлийн жилүүдэд төв банкны алдагдлын хэмжээ хэд байж ирсэн бэ? Гурван их наяд төгрөгийн алдагдлыг баланс дээрээ тусгаад явна гэж байна. Энэ нь эдийн засагт нөлөө үзүүлэхгүй гэж ойлгож болох уу? Төв банкны хуримтлагдсан алдагдал 2.8 их наяд төгрөг болж буурсан. Үлдсэн алдагдал хэзээ дуусах боломжтой вэ?

Мөнгөний бодлогын газрын захирал Б.Баярдаваа

Алдагдал юунаас үүссэн бэ гэдгийг аваад үзэхэд ихэнхдээ санхүүгийн активуудын дахин үнэлгээ, бодлого үйл ажиллагаа, хямд хүүтэй эх үүсвэр зах зээлд нийлүүлсний хүүний зөрүүний алдагдал байдаг. Энэ алдагдлыг эдийн засгийн агуулгаар нь хараад, судлаачийн зүгээс дүгнэлт өгвөл тухайн үеийн хэрэгжиж байсан бодлого эдийн засгийн том зургаа бүрэн харж чадаагүйтэй холбоотой. Өөрөөр хэлбэл, гадаад эдийн засгийн талаас сөрөг шок орж ирснээр төлбөрийн тэнцэл дээр дарамт үүсч байгаа. Үүнтэй зэрэгцээд дотоод эдийн засагт ханшийг хамгаалах зорилгоор ихээхэн хэмжээний интервенцүүд явагдсан. Ханш тогтмол байхыг бүх хүн шаарддаг. Интервенцийн цаана юу яригдаж байна вэ гэхээр тэр дүнтэй тэнцүү хэмжээгээр эдийн засгаас төгрөг татагдаж, гадаад эдийн засаг руу гарч байгаа гэсэн үг. Эдийн засгаас татагдаж байгаа төгрөгийг нөхөхийн тулд эргүүлээд Хөгжлийн банк, Засгийн газрын вексель, Төв банкны хөтөлбөрүүд гээд эдийн засагт төгрөг нийлүүлж эхэлсэн. Нэг талдаа эдийн засгаас валютын ханшийн бодлогоор төгрөг татаад, нөгөө талд нь нийлүүлээд

байдаг. Эцэст нь юу болж хувирсан бэ гэхээр дотоод эдийн засгийн тэнцвэрийн хангах гэж хийсэн бодлого нь эргээд гадаад эдийн засгийн тэнцвэрийг засахад хувь нэмэр үзүүлж чадаагүй. Гадаад эдийн засгийн тэнцвэр буюу төлбөрийн тэнцэл дээр хүндрэл үүсээд эхлэхээр гаднаас зээл авах хувилбар руу орсон. Өөрөөр хэлбэл, Хөгжлийн банкны зээл, Чингис бонд, зарим банкнаас төв банк своп хэлцлээр зээл авч байгаа. Энэ нь төлбөрийн тэнцэл дээр үүсч байгаа доголдлыг нөхсөн боловч эргээд санхүүгийн зардалтай, хүүтэй өр хэлбэрээр гадаад эх үүсвэр бүрдэж байна гэсэн үг. Нэг ёсондоо дотоод эдийн засгийн тэнцвэрийг харж байгаа боловч гадаад эдийн засгийн тэнцвэрийг харж чадалгүй ийм бодлого хэрэгжүүлсэн нь өөрөө эцэстээ хаа нэгэн газар алдагдал хүлээлгэсэн. Тэр алдагдал нь төв банкны баланс дээр гурван их наяд төгрөгийн хуримтлагдсан алдагдал гэж туссан.

25 ТВ: Он гарсаар тэтгэврийн зээлийн хүүг бууруулсан. Үүнээс гадна иргэд бүх төрлийн зээлийн хүүг бууруулаасай гэж хүлээж байгаа. Цаашид ямар төрлийн зээлийн хүүг арилжааны банкууд дээр бууруулах боломжтой вэ, хэдэн хувиар бууруулах боломжтой вэ?

МБГ-ын захирал Б.Баярдаваа

Тэтгэврийн зээлийн хүүг бууруулсан, цаашид эдийн засагт байгаа ерөнхий хүүгийн төвшинг бууруулах хэрэгтэй. Энэ бол аж ахуйн нэгж, иргэд, төв банк, Засгийн газрын хүсэл. Хүмүүс хоёр төрлийн арга зам сонгож байх шиг байна. Нэг хэсэг нь буурахгүй байгаа зээлийн хүүд хязгаар тавья, нөгөө хэсэг нь зах зээлийн зарчмаар

бууруулъя гэсэн байр суурь бий. Төв банкны зүгээс зээлийн хүүг бууруулах стратегийг судлаачид, банкны төлөөллийг оролцуулан өргөн хүрээнд боловсруулаад дуусах шатандаа явж байна. Энэ хүрээнд гурван асуудал яригдаж байгаа. Нэгдүгээрт, зээлийн хүү өндөр байгаа нь манай эдийн засгийн эрсдэлийн түвшин ямар өндөр байгааг илэрхийлж байна. Иймд макро эдийн засгийн эрсдэлийг бууруулах чиглэлд арга хэмжээ авах ёстой. Үүний цаана, төсвийн бодлогын сахилга, макро эдийн засгийн урт хугацааг харсан бодлогууд, түүний хэрэгжилт, төв банкны бодлогын хүүгийн эдийн засагт үзүүлэх нөлөөг сайжруулах, гуравдугаарт санхүүгийн зах зээлийн зуучлал, үр ашгийг сайжруулах, үйл ажиллагаа явуулж байгаа банк, санхүүгийн байгууллагуудын үйл ажиллагааны зардлыг бууруулах чиглэлийн ажлуудыг хийх ёстой. Зарчмын хувьд ийм зүйлүүд яригдаж байгаа. Түүнээс биш зээлийн хүүнд хязгаар тогтоогоод явах нь зохисгүй. Магадгүй 18 хувиар тогтоолоо тэр хүү эргээд өснө. Яагаад гэвэл банк эх үүсвэрийг тогтвортой төвшинд хадгалахаас өөр аргагүй. Хадгаламжаас мөнгөө татаад эхэлбэл, санхүүгийн систем дээр ямар байдал үүсэх вэ гэдэг асуудал яригдана. Дээрээс 18 хувиас дээш хүү шаардаж байгаа тийм хөрөнгө оруулалтын төслүүд санхүүгийн эх үүсвэр олж авч чадахгүй байдалд хүрнэ. Ийм нөхцөл байдалтай байгаа үед зээлийн хүүгийн хязгаар тогтоосноор санхүүгийн зуучлал гэдэг зүйл хязгаарлагдаж хумигдана. Дэлхийн улс орнууд санхүүгийн зуучлалыг хүн бүрт яаж хүргэх вэ гэдэг асуудлыг ярьж байхад Монголд энэ асуудлыг хөндөхгүй байна. Яагаад гэвэл хүн бүр данстай болсон. Хүн бүр зээл авч чаддаг. Энэ асуудал бидэнд байхгүй учир нөгөө талын асуудлыг яриад байна. Тийм болохоор зах зээлийн зарчимтай ноцолдох юм бол одоо хүрсэн байгаа түвшнээсээ ухраад санхүүгийн зуучлалыг хөдөө сумын баг дээр байгаа малчинд яаж хүргэх вэ гэдэг рүү ухрах эрсдэл бий. Зээлийн хүү аажимдаа тогтвортойгоор буурах юм.

Монгол ТВ: Монголбанк эдийн засаг, ажлын байруудыг дэмжих хөтөлбөрүүдээ зогсоож байна гэсэн мэдээлэл байна. Зогсоох шалтгаан юу байсан бэ? Хөтөлбөрийг зогсоож байгаа бол цаашид эдийн засгийн өсөлтийг дэмжих арга замуудаа хэлж өгөөч.

МБГ-ын захирал Б.Баярдаваа:

Дэлхийн төв банкуудын туршлагыг харах юм бол Засгийн газрын төсвийн шинж чанартай үйл ажиллагаа руу оролцдог, хөтөлбөрүүдийг хэрэгжүүлдэг, өөрийн үндсэн зорилтоосоо давсан арга хэмжээ рүү ордог туршлага маш бага. Би бол мэдэхгүй байна. Хүмүүс юу ярьдаг вэ гэхээр Япон, Вьетнам зэрэг улс орныг нэрлэдэг. Эцэсдээ төв банкаараа дамжуулж хэрэгжүүлж байгаа боловч эх үүсвэр, зардал бүх зүйл нь Засгийн газрын төсөв дээрээ суугаад явсан байдаг. Дээрээс нь бусад улс оронд төсвийн шинжтэй үйл ажиллагаа хэрэгжүүлснээсээ болоод төв банкууд нь алдагдал хүлээгээд, зарим тохиолдолд Засгийн газрын нэрийн өмнөөс гадаад зах зээлд бонд босгож эх үүсвэр оруулж ирээд тэр нь алдагдал хүлээгээд буцсан жишээнүүд ч олон бий. Бусад улс орны хийж үзээд, алдсан жишээг бид давтсан. Энэ нь магадгүй хууль эрх зүйн орчны хамгаалалт сул байсантай холбоотой байх. Төв банкны тухай хуулийн нэмэлт өөрчлөлтөөр төсвийн шинж чанартай үйл ажиллагааг санхүүжүүлэхэд нэлээд хатуу шалгуур, шаардлагууд сууж өгсөн. Судлаач хүний хувьд миний хувийн байр суурь бол засаг, төв банк өөрөө төсөл хөтөлбөр хэрэгжүүлээд компани байгуулаад ажлын байр нэмэгдүүлнэ гэдэг маш буруу сонголт. Энэ нь эргээд тэр үйл ажиллагааг хэрэгжүүлэхтэй холбоотой зардал төв банк, Засгийн газрын нуруун дээр өр, алдагдал болж сууж байдаг. Гэтэл энэ төслүүд нь тийм үр ашигтай, үр дүнтэй болж чадах уу гэвэл асуудалтай. Олон жишээг үүний цаана ярьж болно. Хувийн сектор эрсдэл, өрөө үүрээд зээлээ аваад ажлын байр нэмэгдүүлээд, төсөл хөтөлбөр хэрэгжүүлээд явах нь илүү үр ашигтай хувилбар байх болно.

25 ТВ: Ипотекийн зээлийг иргэд хүлээж харж байдаг. Зорилтод бүлэгтээ хүрэхгүй байна гэдэг нь нэлээд том асуудал болоод байна. Агаарын бохирдлыг бууруулахын тулд гэр хорооллын иргэдийг орон сууцжуулах, ипотекийн зээлд хамруулснаар үр дүн гарна гэдэг шүү дээ?

НУСЗЗГ-ын захирал А.Энхжин:

Ипотекийн санхүүжилт эрэлтээ бүрэн хангаж чадахгүй байгаа. Цаашид хүртээмжийг нэмэгдүүлэх шаардлага зайлшгүй байгаа. Сангийн яамны зүгээс Татаасын журам боловсруулж Барилга хот байгуулалтын яам, Монголбанкны хамтарсан ажлын хэсгийн хурал дээр танилцуулсан. Энэ асуудал Сангийн яамнаас

шийдэгдээд явбал 2019 оноос Засгийн газрын татаасын журам хэрэгжих болов уу. Энэ тохиолдолд хүртээмжийг өнөөгийн түвшнөөс хоёр дахин нэмэгдүүлэх боломжтой. Зорилтод бүлгийн хувьд Монголбанкнаас олгож байгаа санхүүжилтийн 25 хувийг орон нутагт олго гэсэн шаардлагыг банкуудад тавьдаг. Энэ талаар зээл олгосон зээлийн тайланг шалган банкуудтай хамтарч ажилладаг. Гэр хорооллын дахин төлөвлөлтийн бүсүүдэд ипотекийн зээлийн хүртээмжийг яаж нэмэгдүүлэх тал дээр Монголбанкнаас арилжааны банкуудтай ярилцдаг. Гэр хорооллын айл өрхүүдийг дахин төлөвлөгдсөн барилгуудад зээл олгоогүй гээд Монголбанкнаас шаардлага тавихад хүндрэлтэй. Учир нь эцсийн эрсдэлийг банкууд өөрсдөө хүлээж бодлогын хүрээндээ зээлээ олгоод явж байгаа. Засгийн газрын татаасын журмыг хэлэлцэж байхад гэр хорооллын дахин төлөвлөлтийн бүсэд баригдсан барилгаас зээл авсан тохиолдолд урьдчилгаа төлбөр 25 хувь болгох, зээлийн хүүг тодорхой хэмжээнд бууруулах талаар ярьж байсан. Энэ хэлбэрээр асуудлыг шийдээд явж болох байх. Иргэдийн зүгээс Монголбанкинд тавьдаг нэг хүсэлт, шаардлага бол арилжааны банкууд өөрсдийн харилцагч байгууллагуудын орон сууцанд зээл олгоод бусад иргэдэд зээл олгохгүй байна гэдэг. Энэ дагуу банкуудад зээлдэгчдэд тэгш хандаж зээлийг олго гэсэн шаардлага тавьж байгаа. Мөн энэ дагуу Монголбанкнаас 2018 оны хоёрдугаар улиралд банкуудад шалгалт хийхээр төлөвлөж байна.

VTV телевиз: Засгийн газраас алт цэвэршүүлэх үйлдвэр байгуулах талаар ярьж байгаа. Манай улс дотооддоо алт цэвэршүүлэх боломж бий юу?

НУСЗЗГ-ын захирал А.Энхжин

Монголбанкны зүгээс энэ талаар судалгаа хийж үзсэн. Судалгааны үр дүнгийн талаар танилцуулахаас өмнө Монголбанкны алт худалдан авах үйл ажиллагааны талаар товчхон танилцуулъя. Төв банкны тухай хуулиар Монголбанк өөрийн эзэмшил дэх алтыг мөнгөжсөн алтны стандартад хүргэж цэвэршүүлэх, гадаадын байгууллагад хадгалуулснаар нөөцөд тооцогддог. Монголбанк дотоодын зах зээлээс алт худалдан авалтыг нэмэгдүүлэхийг зорьж байгаа. Дотоодын худалдан авалтыг дэмждэг нэг зүйл нь алт цэвэршүүлэлтийн зардал юм. Өнгөрсөн онд Монголбанк дотоодын зах зээлээс алт худалдан авахдаа цэвэршүүлэлтийн үнийг

тооцолгүйгээр шууд худалдан авч байсан. Одоогийн нөхцөлд Лондонгийн үнэт металын зах зээлийн үнээс хоёр ам.доллараар хямд үнэтэй тэнцэх дүнгээр алтыг худалдан авч байна. Энэ нь хамгийн өндөр үнийн дүн. Алт цэвэршүүлэх зардлыг Монголбанк бага байлгаж чадсанаар алт тушаах сонирхлыг нэмэгдүүлж, нөөцийн хэмжээ нэмэгдэнэ. Цэвэршүүлэх үйлдвэртэй холбоотой хийсэн судалгааны үр дүнгээс харахад Монгол Улсад үйлдвэр байгуулсан тохиолдолд алт цэвэршүүлэлтийн зардал 3-4 дахин нэмэгдэнэ гэсэн тооцоо гарч байгаа. Одоогийн байдлаар Монголбанк 1.5-2 ам.долларыг унц тутмын цэвэршүүлэлтийн зардалд төлдөг бол энэ нь нэмэгдээд 6-7 ам.доллар болж болзошгүй. Үүнээс гадна болгоомжилж байгаа зүйл нь алт цэвэршүүлэх үйлдвэр барьснаар 5 орчим жил болсны дараагаар Лондонгийн үнэт металын биржээс сайн цэвэршүүлэгч гэсэн батламж авдаг. Энэ батламжийг авсан цэвэршүүлэх үйлдвэрийн алтыг мөнгөжсөн алтанд тооцон олон улсын зах зээлийн стандартыг хангасан гэж үздэг. Энэ хугацаанд Монгол Улс худалдан авсан алтаа дотоодын зах зээл дээр цэвэршүүлээ гэж үзэхэд дахин олон улсын сертификат авах хүртэл хүлээх, эсвэл доогуур үнээр худалдах гэсэн асуудал гарч ирнэ. Тийм учраас Монголбанкны зүгээс ийм хоёр болгоомжлол байна. Засгийн газрын түвшинд хэлэлцэж үзэх болов уу.

Монгол ТВ: Одоогоор инфляци 6 хувьтай байна. Зорилт 8 хувь гэж байгаа. Нэг ёсондоо зорилтот түвшин рүү нэлээд ойртсон байна. Ийм үед мөнгөний бодлогоор эдийн засгийг дэмжих боломж, орон зай байгаа юу? Энэ онд инфляци зорилтот түвшинд хадгалагдах уу?

МБГ-ын захирал Б.Баярдаваа

Дөрөвдүгээр сарын байдлаар Улаанбаатар хотын инфляци 6.7, улсын хэмжээнд 6 хувьтай байгаа. Энэ нь жилийн инфляци. Өнгөрсөн оны дөрөвдүгээр сараар энэ оны дөрөвдүгээр сар хүртэл өргөн хэрэглээний бараа, бүтээгдэхүүний үнэ ийм хэмжээгээр өссөн байна гэсэн үг. Оны эхнээс авч үзэхэд Улаанбаатар хотын хэмжээнд 4.2, улсын хэмжээнд 3.8 хувь байгаа. Энэ дотроо суурь инфляци гэж ярьдаг. Оны эхнээс 1.8 хувь байгаа. Суурь инфляци дотроо улирлын шинж чанартай хүчин зүйлсийн үнийн өсөлтүүд нэлээд бий. Тухайлбал, хатуу түлшний үнэ буюу гэр хороололд худалдаалагдаж байгаа нүүрсний үнэ өнгөрсөн оны

наймдугаар сараас хойш 50 хувийн өсөлттэй гарсан. Мөн согтууруулах ундаа 0.48 хувь, хүнсний ногоо 0.4 хувь, өнгөрсөн жил гантай байсан учир хөдөө орон нутагт нийт ургацын 40-50 хувийг алдсан. Үүнтэй холбоотой дөрөвдүгээр сард хүнсний ногооны үнийн өсөлт бусад жилүүдтэй харьцуулахад өндөр байлаа. Эдгээр бараа бүтээгдэхүүнүүд 6.7 хувийн инфляцийн 2.5 орчим хувийг тайлбарлаж байна. Монголбанкны зүгээс бодлогын хүүг бууруулах шийдвэр гаргахдаа ч хэлж байсан. Энэ он болон ирэх онд инфляци зорилгод түвшин болох 7-8 хувийн төвшинд хадгалагдана гэсэн төсөөлөлтэй байна.

ТВ8: Хөрөнгө оруулалтын банкны тухай хууль хэлэлцэгдэж эхэлсэн. Энэ хуулийн талаар Монголбанк ямар байр суурьтай байгаа вэ?

Хууль, эрх зүйн газрын захирал Д.Ганбат

Монголбанк 2016 оны сүүлээс банкны салбарын эрх зүйн шинэчлэлийн хөтөлбөрийг гаргасан. Дунд хугацаандаа буюу 5 жилийн хугацаанд 10 орчим хуулийн төслийг боловсруулж батлуулахаар явж байна. Өнөөдрийн түвшинд боловсруулж батлуулахаар төлөвлөж байсан нийт хуулиудынхаа 50 хувийг батлуулсан байна. Тухайлбал, Төв банкны тухай хууль, Банкны тухай хууль, Банкин дахь мөнгөн хадгаламжийн даатгалын тухай хууль, Мөнгө угаах терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль, Төлбөрийн системийн тухай хууль гэсэн таван төрлийн хууль УИХ-аар батлуулсан байна. Нэг жил хагасын хугацаанд хөтөлбөрийнхөө 50 орчим хувийг хангаад явж байна гэсэн үзүүлэлт гарсан. Энэ нь Монголбанкны өнөөгийн үйл ажиллагаа маш эрчимтэй, үр дүнтэй явж байгаагийн нэг илрэл юм. Хөрөнгө оруулалтын банкны тухай хуулийн төслийг УИХ-ын нэр бүхий гишүүд өргөн барьсан. Энэ хуулийн төслийг УИХ нэгдсэн чуулганаар хэлэлцээд хуулийн төслийг хэлэлцье гэсэн байгаа. Хуулийн төсөл эдийн засгийн байнгын хорооны ажлын хэсгийн хурлаар хэлэлцэгдээд явж байгаа. Ажлын хэсэг хуулийн төслийг нэлээд боловсронгуй болгож нэмэлт, санаа, саналыг тусгасан хувилбарыг гаргасан. Ойрын хугацаанд УИХ-ын нэгдсэн чуулганаар хэлэлцэгдээд батлагдах байх гэж хүлээж байна.

Блүүмбэрг ТВ: Банкуудын чанаргүй зээлийн түвшин өндөр хэвээр байна. Төв банк санхүүгийн тогтвортой байдлыг хангагч гэдэг утгаараа энэ

асуудалд яаж анхаарах гэж байна вэ?

ХШГ-ын Бүтцийн өөрчлөлт, бодлогын газрын захирал Ё.Мөнхбат

Системийн хэмжээнд хугацаа хэтэрсэн зээл 6.8 хувьтай, чанаргүй зээл 7.6 хувьтай байгаа. Эдийн засгийн нөхцөл байдлаас шалтгаалаад чанаргүй зээл тогтмол өсч байсан бол сүүлийн үед уул уурхайн салбар, гадаад нөхцөл байдлаас шалтгаалаад эдийн засаг сэргэх дүр зураг ажиглагдаж байгаа. Энэ нь тодорхой хэмжээгээр чанаргүй зээлд нөлөөлж байгаа боловч, чанаргүй зээлийг шийдвэрлэхэд хүндрэлүүд гарч байна. Монголбанк чанаргүй зээлийг шийдвэрлэх тал дээр онцгойлон анхаарч ойрын хугацаанд Санхүүгийн тогтвортой байдлын зөвлөлийн хурлаар чанаргүй зээлийг шийдвэрлэх стратегийг батлахаар ажиллаж байна. Чанаргүй зээлийн стратегид юу орох вэ гэхээр нэг талаас банкууд чанаргүй зээл дээр өөрийн хүчин чармайлтын хүрээнд хэрхэн ажиллах талаар журам боловсруулан олон нийтэд вэб сайтаараа дамжуулан мэдээлэл хүргэсэн байгаа. Үүнээс гадна банк өөрийн хүчин чармайлтаар шийдвэрлэхэд тодорхой хэмжээний хүндрэл бий. Тийм учраас тодорхой хуулиудад нэмэлт өөрчлөлт оруулснаар хууль эрх зүйн орчныг бүрдүүлэх шаардлагатай. Ойрын хугацаанд чанаргүй зээлийн стратегийг боловсруулж олон нийтэд танилцуулах болно.



3. МӨНГӨ, САНХҮҮГИЙН СТАТИСТИК /Мөнгөний нийлүүлэлт/

Зураг 3.1 Мөнгөний нийлүүлэлт, өсөлт, их наяд ₮



Зураг 3.2. Мөнгөний үзүүлэлтүүдийн сарын өөрчлөлт, тэрбум ₮




- M2 мөнгөний жилийн өсөлт 30,0%-д хүрч 16.2 их наяд ₮ болов.
- Тухайн сард M2 мөнгө 0,9%-иар (144,4 тэрбум ₮) өсөв.
- Үүнд M1 мөнгө 3,2% (88,0 тэрбум ₮), бусад хадгаламж, харилцах 0,4% (56,4 тэрбум ₮) -иар өссөн нь нөлөөлөв.
- M1 → Төгрөгийн харилцах 17,8 тэрбум, хадгаламжийн байгууллагаас гадуурх мөнгө 70,1 сая ₮-р өсөв. Бусад хадгаламж, харилцах → Төгрөгийн хадгаламж 79,5 тэрбум ₮-р, валютын харилцах 13,1 тэрбум ₮-р өсч, хадгаламж 36,2 тэрбум ₮-р буурав.

12

2. ГАДААД СЕКТОРЫН СТАТИСТИК


2.1. Төлбөрийн тэнцлийн статистик, 2018 оны I улирал




MU-р орсон ШХО, 2018,I
465,2 сая \$ /цэвэр дүн

3. МӨНГӨ, САНХҮҮГИЙН СТАТИСТИК /Мөнгөний нийлүүлэлт/

Зураг 3.3. Мөнгөний нийлүүлэлтийн бүтэц




Зураг 3.4. Иргэдийн хадгаламж, тэрбум ₮




3. МӨНГӨ, САНХҮҮГИЙН СТАТИСТИК /Мөнгөний нийлүүлэлт/

Зураг 3.5. Төв банк, хадгаламжийн байгууллагуудын гадаад, дотоод актив




Зураг 3.6. Дотоод цэвэр активын бүтэц, тэрбум ₮




3. МӨНГӨ, САНХҮҮГИЙН СТАТИСТИК /Хүү/

Зураг 3.7. Зээлийн ЖДХүү



Зураг 3.8. Хадгаламжийн ЖДХүү



- Тухайн сард олгосон зээлийн хүү **₮ 19,1%**
- Үлдэгдлээрх зээлийн хүү **₮ 11,3%**
- Тухайн сард шинээр татсан хадгаламжийн хүү **₮ 11,5%**
- Үлдэгдлээрх хадгаламжийн хүү **₮ 3,9%**
- Төгрөгийн зээлийн хүү **₮ 18,0%**
- Валютын зээлийн хүү **₮ 10,9%**
- Төгрөгийн (тухайн сард) **₮ 12,8%**
- Валютын (тухайн сард) **₮ 5,3%**

15

3. МӨНГӨ, САНХҮҮГИЙН СТАТИСТИК /Зээл/

Зураг 3.9. Зээл, зээлийн чанар



Зураг 3.10. Зээлийн үлдэгдэл, эдийн засгийн салбарын ангиллаар



- Нийт зээл **14,4 их наяд ₮** (₮ зээл **11,2 их наяд ₮**, \$ зээл **3,2 их наяд ₮**)
- Хэвийн зээл өмнөх сараас **306,5 тэрбум ₮** буюу 2,6%-иар нэмэгдсэн.
- Хугацаа хэтэрсэн зээл өмнөх сараас **43,3 тэрбум ₮** буюу 4,6%-иар өссөн.
- Чанаргүй зээл өмнөх сараас **27,0 тэрбум ₮** буюу 2,2%-иар буурсан байна.

16



Ипотекийн 8% зээл

2018-IV сар



ХӨТӨЛБӨРИЙН САНХҮҮЖИЛТ /ЗГ+МБ/

IV сард:
45.1 тэрбум ₮
2018 оны эхний 4
сард: **93.3**


БАНКНААС ОЛГОСОН 8%-ИЙН ЗЭЭЛ

IV сард:
20.7 тэрбум ₮
2018 оны эхний 4
сард: **72.6** тэрбум ₮

НЭМЭГДСЭН ЗЭЭЛДЭГЧИЙН ТОО


IV сард :
269 зээлдэгч
2018 оны эхний 4
сард: **937** зээлдэгч

Тухайн сард олгосон зээл



■ Нийт ипотекийн зээл ■ Хөтөлбөрийн зээл

Зээлдэгчийн тоо



■ Нийт ипотекийн зээл ■ Хөтөлбөрийн зээл

Сонирхолтой статистик

ДУНДАЖ ЗЭЭЛИЙН
ХЭМЖЭЭ



75.0 сая ₮

ЗЭЭЛИЙН ДУНДАЖ
ХУГАЦАА



21.0 жил

ЧАНАРГҮЙ
ЗЭЭЛ



0.8 хувь



МӨНХ ХААНЫ МӨНГӨН ЗООГ

1251-1260 он
БУЛГАР ХОТ

Жин

0.9 гр

Голч

1.9 см

1251-1260

Нүүр тал

“Аугаа их хаан Мөнх” гэж арабаар бичсэн. Хоёр тийш харсан сэрээ тамгатай.

Ар тал

“Булгарт дэлдүүлэв” гэж арабаар бичсэн.



О.БАНЗРАГЧ: БАНКНЫ САЛБАРТ ТӨРИЙН ӨМЧЛӨЛ БАЙХ ХЭРЭГГҮЙ ГЭЖ БОДДОГ



Улаанбаатар хотын банкны тэргүүн дэд захирал О.Банзрагчтай ярилцлаа.

АЖЛЫН ТУРШЛАГА

2001-2004 онд Худалдаа хөгжлийн банк Маркетингийн менежер мөн актив хариуцсан менежер

2004-2005 онд Улаанбаатар хотын банк Харилцагчийн газрын захирал

2005-2007 онд Улаанбаатар хотын банк Бизнес банкны газрын захирал

2007-2014 онд Улаанбаатар хотын банк Дэд захирал

2014 одоог хүртэл Улаанбаатар хотын банк Тэргүүн дэд захирал

БОЛОВСРОЛ

1987-1997 онд 13-р сургууль Бүрэн дунд

1997-2001 онд МУИС-ЭЭС Банкны эдийн засагч мэргэжилтэй

УЛААНБААТАР ХОТЫН БАНК ХЭДЭН ОНД АНХ БАЙГУУЛАГДАЖ БАЙСАН БЭ ГЭДЭГ ТҮҮХЭЭС ЯРИЛЦЛАГАА ЭХЭЛЬ?

-Манай банк 1999 онд байгуулагдсан. Анх байгуулагдахдаа “Улаанбаатар сан” гээд Улаанбаатар хотын захиргааны 100 хувийн хөрөнгө оруулалттай, төрийн мэдлийн банк байсан. Тухайн үедээ нийслэлийн иргэдэд хотын үйлчилгээг илүү түргэн шуурхай, ойр хүргэх зорилгоор нээгдэж байсан. Өнөөдрийн байдлаар хувийн хэвшилд 100 хувь шилжээд байна. Тухайн үед банкуудын дүрмийн сан 50 сая төгрөг байсан бөгөөд Монголбанкнаас банкуудын чадавхийг сайжруулах зорилгоор дүрмийн санг тогтмол өсгөж, ирсэн. Ингэснээр нийслэлийн төсөв Монголбанкны шалгуурыг хангаж чадахгүйд хүрч, хүссэн хүсээгүй хувийн хэвшилд санал болгосон байдаг. Өнөөдрийн байдлаар

манай банк хотод 39 нэгжээр харилцагчиддаа үйлчилж байна. 480 гаруй ажиллагчтай. 1.3 их наяд төгрөгийн активтай системийн ач холбогдолтой банк болж өргөжөөд байна.

ОРОН НУТАГТ САЛБАРАА НЭЭХ ЗОРИЛГО БИЙ ЮУ?

-Эдийн засгийн нөхцөл байдлыг харна. Мэдээж тодорхой хэмжээнд судалгаа, шинжилгээ хийгдэж байгаа. Одоогийн байдлаар орон нутагт салбар байхгүй.

1999 ОНД “САН” НЭРТЭЙГЭЭР БАЙГУУЛАГДАЖ БАЙСАН. ТУХАЙН ҮЕД БАНКУУДЫН ДАМПУУРАЛ БОЛСОН. БАНК, САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГУУД ХҮНД ХЭЦҮҮ ЖИЛҮҮДИЙГ ҮДЭЖ БАЙСАН. ЭНЭ ҮЕД “УЛААНБААТАР ХОТЫН БАНК” ХЭРХЭН АЖИЛЛАЖ БАЙВ.

-Би 2004 оноос хойш Улаанбаатар хотын банкинд ажиллаж байна. Тэрнээс өмнөх түүхийг сайн мэдэхгүй. Гэхдээ тухайн үеийг

эргээд харвал ихэвчлэн төрийн өмчийн компаниуд дампуурч байсан. Үндсэндээ засаглалын асуудал. Харин сүүлд дампуурсан хоёр, гурван банк бол харамсалтай нь тухайн үеийн эдийн засгийн нөхцөл байдлаасаа л болоод дампуурсан. Тэрийг менежментийн буруу гэж хэлэхэд хэцүү. Би банкнаас бусад салбарыг сайн мэдэхгүй. Гэхдээ банкны салбарт төрийн өмчлөл байх шаардлагагүй гэж боддог.

2008 ОНД ДЭЛХИЙ НИЙТИЙН САНХҮҮГИЙН ХЯМРАЛ БОЛСОН. 2013 ОНООС ЭХЛЭЛТЭЙ ЭДИЙН ЗАСГИЙН ХҮНДРЭЛҮҮД БАНКНЫ СИСТЕМД СӨРГӨӨР НӨЛӨӨЛСӨӨР ИРСЭН. ЭНЭ НӨХЦӨЛ БАЙДАЛ БАНКУУДААС ЭРСДЭЛЭЭС ХАМГААЛАХ МЕНЕЖМЕНТЭЭ САЙЖРУУЛАХЫГ ШААРДАЖ БАЙГАА. ТАНАЙ БАНКНЫ ХУВЬД ЭНЭ ЧИГЛЭЛД ХЭРХЭН АНХААРЧ БАЙНА ВЭ?

-Эрсдэл гэхээр удирдаж чадах болон чадахгүй эрсдэл гэж хоёр өөрөөр харж болно. Мэдээж 2007-2008 онд дэлхий нийтийг хамарсан хямрал болсон. Энэ Монголоос шалтгаалаагүй. Гэхдээ эргээд санавал тэр үеийн хямралыг манай эдийн засаг бараг үндсэндээ мэдрэхгүйгээр өнгөрөөсөн. Тухайн үед эдийн засаг харьцангуй жижиг байсан. Хоёрдугаарт, Оюутолгойн бүтээн байгуулалт орж ирсэн. Жижиг эдийн засагт эрсдэлийг удирдахад харьцангуй амар. Харин том эдийн засагт хэцүү. Тэгэхээр манайх уул уурхайн орон. Тийм учраас түүхий эдийн зах зээлийн үнээс их хамааралтай. Монголчууд түүхий эдийн үнийн эрсдэлийг удирдаж чадахгүй шүү дээ. Банкуудын хувьд эрсдэлийг удирдах олон аргачлал

бий. Мэдээж хуулиар тогтоосон хязгаарлалтууд ч бий. Түүнээс гадна банкууд эдийн засгийн салбарууд дахь эрсдэлийг тогтмол харж, анхаарч байдаг. Барилгын салбар, үйлчилгээний салбар, уул уурхай, жижиглэн худалдаа гэх мэтчилэн. Манай банкны хувьд зөвхөн Улаанбаатар хотод салбар, нэгжүүдээрээ дамжуулан үйл ажиллагаа явуулдаг учраас эрсдэлийг төвлөрүүлж удирдаж чадаж байгаагаараа давуу талтай.

УУЛ УУРХАЙ, БАРИЛГЫН САЛБАРТ ЧАНАРГҮЙ ЗЭЭЛ НЭМЭГДЛЭЭ. ТАНАЙ БАНК ЭНЭ САЛБАРТ ХЭР ИХ ЗЭЭЛ ОЛГОВ? ЧАНАРГҮЙ ЗЭЭЛИЙН ҮЗҮҮЛЭЛТ ХЭДЭН ХУВЬТАЙ БАЙГАА ВЭ?

-Манай банкны хувьд дотоодын эрсдэлийн менежментийнхээ дагуу нэг салбарт олгох зээл нийт зээлийн 20 хувиас хэтэрдэггүй. Уул уурхай ч тэр, барилга ч тэр. Бүгд л адилхан. Тэгэхээр удирдаж болох түвшиндээ л байна. Ерөнхий банкны системийн хувьд уул уурхайн салбарт чанаргүй зээлийн төвлөрөл өндөр байгаа. Гэхдээ өнгөрсөн оны сүүлээс түүхий эдийн үнийн өсөлттэй холбоотойгоор энэ салбарын зээлийн чанар сайжирч байна. Манай улсын эдийн засаг өөрөө онцлогтой. Хөгжиж байгаа орон, дээр нь уул уурхайн салбараас хамааралтай учраас гадаад валютын урсгалын бараг 85-90 хувь нь зөвхөн уул уурхайн орлого байдаг. Үүнийгээ дагаад эдийн засгийн мөчлөг маань уул уурхайн салбарын орлого 1-6 жилийн дотор бусад салбар руугаа орох байдлаар явдаг. Эхлээд уул уурхайн салбарт өсөлт бий болдог. Улмаар уул уурхайн салбарт бий болсон орлого бусад салбар руу шилждэг гэсэн

үг. Тэгэхээр манай улс ОУВС-ийн хөтөлбөрт хамрагдсан. Өнгөрсөн онд банкны системийн хэмжээгээр Активын чанарын үнэлгээнд хамрагдлаа. Яг активын чанарын үнэлгээг эхэлж байх үед байдал сайнгүй байсан. Харин түүнээс хойш бүтэн жил өнгөрөхөд нөхцөл байдал нэлээд сайжирлаа. Системд гэрэл, гэгээ ажиглагдаж эхэлсэн. Би 2019 оноос эдийн засгийн байдал улам сайжрах болов уу гэж хүлээж байгаа. Чанаргүй зээлийн хувь хэмжээний тухайд манайх системийн дунджаас бага байгаа. Системийн хэмжээгээр чанаргүй зээл нийт зээлд 3 орчим хувь байсан санагдаж байна. Манайх тэрнээс бага буюу 2 орчим хувь байгаа.

ЧАНАРГҮЙ ЗЭЭЛИЙГ ШИЙДВЭРЛЭХТЭЙ ХОЛБООТОЙГООР АКТИВЫН УДИРДЛАГЫН КОМПАНИЙГ БАЙГУУЛАХ АСУУДАЛ ЯРИГДАЖ БАЙНА. ТАНЫ БОДЛООР ЧАНАРГҮЙ ЗЭЭЛИЙГ ШИЙДВЭРЛЭХ СТРАТЕГИ ЯМАР БАЙХ ЁСТОЙ ВЭ?

-Хамгийн гол нь хууль эрх зүйн орчноо л сайжруулах ёстой. Компани байгуулах нь гол асуудал биш.

ТУХАЙЛБАЛ?

-Тухайлбал, банк бол зуучлагч байгууллага. Хүмүүсээс хадгаламж аваад, тэрнийгээ бусдад зээлдэж, дундаас нь тодорхой хэмжээний ашиг авч байдаг. Тэгэхээр пассив талаа харвал хугацаатай болон хугацаагүй хадгаламж гэж бий. Гэхдээ хугацаатай болон хугацаагүйгээс үл хамаарч, харилцагчийн анхны шаардлагаар мөнгийг өгдөг. Ийм хууль эрх зүйн орчинтой. Гэтэл нөгөө талдаа харилцагчаас татсан мөнгөөрөө

зээл олгодог. Би иргэн А-аас 100 төгрөгийн хадгаламж татаад, Монголбанкинд 15 төгрөгийг нь байршуулаад, үлдсэн 85 төгрөгийг нь Б-д зээлүүлчихсэн. Нэг жилийн хугацаатай хадгаламж татаад, нэг жилийн хугацаатайгаар зээлдүүлсэн. Ингээд явж байтал иргэн А мөнгөө авъя гэвэл бид шууд л өгнө. Нөгөө талдаа бид нэг жилийн хугацаатай зээлүүлсэн мөнгөө хугацаанаасаа өмнө төл гэж шаардаж чадахгүй. Гэхдээ хууль эрх зүйн орчны тухайд зээлийн харилцагчийг гэрээний хугацаа дуусахаас өмнө дуудаж авчрах тухай огт яриагүй. Бидний хүсч байгаа зүйл юу гэхээр хууль эрх зүйн тодорхойгүй байдлаас болж, зарим тохиолдолд чанаргүй зээлийг шүүхийн журмаар шийдвэрлэхэд зээлийн гэрээний хугацаа дууссанаас хойш 5 хүртэлх жил зарцуулж байна. Тэгэхээр шүүхэд өгснөөс хойш хэдий хугацаанд шийдэгдэх вэ гэдэг нь тодорхой байх хэрэгтэй байна. Тэгж байж, би эрсдэлээ удирдана шүү дээ. Гурван шатны шүүх, шүүхийн шийдвэр гүйцэтгэл гээд бүх процесс 1-2 жилийн дотор дуусч байвал болж байна. Ийм тодорхой байдал л чухал юм. Таны түрүүн хэлсэнчлэн актив удирдлагын компани байгуулна гэдэг бас зөв. Зээл гэдэг бол өөрөө бүтээгдэхүүн. Олон улсад чанаргүй болсон активуудаа хувьчлаад, бусдад шилжүүлэх, худалдах эрх зүйн тогтолцоо бий. Гэхдээ манай улсын хувьд одоохондоо үүнийг хийх амаргүй л байх болов уу. Шаардах эрхээ бусдад шилжүүлнэ гэсэн үг шүү дээ. Хэрвээ хийж чадвал энэ банкуудын хөрвөх чадварт маш сайн нөлөө үзүүлнэ. Эрсдэлийг удирдахад ч

амар, хялбар болно. Гэхдээ үүнээс гадна чанаргүй болсон зээлийг шүүхийн журмаар шийдүүлэх эрх зүйн орчныг маш тодорхой л болгомоор байна.

ТАНАЙ БАНКНЫ ХУВЬД ИПОТЕКИЙН ХӨТӨЛБӨРИЙГ ТҮЛХҮҮ ДЭМЖИЖ, ЭНЭ ЧИГЛЭЛД ЗЭЭЛ ИХ ОЛГОДОГ ГЭЖ ОЙЛГОСОН. ОДООГООР ИПОТЕКИЙН ХӨТӨЛБӨРИЙН САНХҮҮЖИЛТ БАГАСЧИХААД БАЙГАА. ИЙМ ҮЕД ТАНАЙ БАНК ИПОТЕКИЙН ЗЭЭЛ ОЛГОЛТ ДЭЭР ЯМАР БОДЛОГО БАРИМТАЛЖ АЖИЛЛАЖ БАЙНА ВЭ?

-8 хувийн эх үүсвэр буюу Засгийн газрын хөтөлбөрийн эх үүсвэр тодорхой хэмжээгээр нэмэгдээсэй гэж хүсдэг. Банкуудын хувьд эх үүсвэрийн өртөг өндөр учраас бага хүүтэйгээр ипотек олгох боломжгүй. Гэхдээ сүүлийн хэдэн сарын хугацаанд хадгаламжийн хүү буурч эхэлсэн. Эдийн засгийн нөхцөл байдал сайжраад, цаашдын ирээдүй, төлөв ч бас гэгээлэг харагдаж байгаа. Тийм учраас банкууд эх үүсвэрийнхээ хүүг тодорхой хэмжээгээр, үе шаттай бууруулж эхэлсэн. Он гарснаас хойш банкуудын зээл олголт нэлээд идэвхжиж байгаа. Гэхдээ ихэнх нь хэрэглээний зээл болчихоод байна. Найман хувийн ипотекийн зээлийн эх үүсвэр бага учраас хүмүүс бусад хэрэглээний төрлийн зээл рүү хошуурч байна. Автомашин, тавилга гэх зэргээр үндсэндээ импортыг дэмжсэн зээл гэсэн үг. Тэгэхээр найман хувийн зээлийг зохистой хэмжээгээр нь явуулбал, хүмүүс хэрэглээгээ зохистой түвшинд байлгахад их үр дүнгээ өгнө. Хэрэглээ буюу импортыг дэмжсэн зээл нэмэгдэж байгаа нь бидний санааг зовоож байгаа.

Яг активын чанарын үнэлгээг эхэлж байх үед байдал сайнгүй байсан. Харин түүнээс хойш бүтэн жил өнгөрөхөд нөхцөл байдал нэлээд сайжирлаа. Системд гэрэл, гэгээ ажиглагдаж эхэлсэн.

**МОНГОЛБАНК БОЛОН ЗАСГИЙН
ГАЗРААС САРД ХОЁР УДАА
ИПОТЕКИЙН ЗЭЭЛИЙН ЭХ
ҮҮСВЭРИЙГ БАНКУУДАД ОЛГОЖ
БАЙГАА. ЭНЭ ЭХ ҮҮСВЭРИЙН
ХЭМЖЭЭ ТАНАЙ БАНКИН ДЭЭР
ИРЖ БУЙ НИЙТ ХҮСЭЛТИЙГ
ХЭДЭН ХУВИЙГ ХАНГАЖ БАЙНА
ВЭ?**

-Ерөнхийдөө 20-25 хувийг л хангаж байна. Нэг ёсондоо манай бодит төлбөрийн чадвартай хүмүүсийн эрэлт 1 тэрбум төгрөг байхад, миний авч байгаа эх үүсвэр 200 сая төгрөг гэсэн үг. Тэгэхээр илүүдэл эрэлт байна. Хамгийн гол нь энэ бол төлбөрийн чадвартай эрэлт юм. Зүгээр нэг хүсэлт биш.

**ТАНАЙ БАНК ӨӨРИЙН ЭХ
ҮҮСВЭРЭЭР ТОДОРХОЙ
ХЭМЖЭЭНД ИПОТЕКИЙН ЗЭЭЛ
ОЛГОЖ БАЙГАА БАЙХ?**

-Манай өөрийн эх үүсвэрээр олгож байгаа зээл жилийн 16 хувь. Тийм учраас хүмүүс тэр бүр авч чадахгүй байна. Ипотекийн 8 хувийн зээлийн тухайд хүмүүс янз бүрийн өнцгөөр л тайлбарладаг. Хязгаарлах ёстой, бодлогын бус зээл гэх ч юм уу. Гэхдээ үүний нөгөө талд аливаа зүйлд алдагдлыг хүлээн зөвшөөрч байж, үр дүнд хүрэх тал бий. Нийслэлийн утааны асуудал гээд их ярьдаг. Утааг шийдсэн гол арга нь дэлхий нийтэд ерөөсөө л орон сууцжуулалт. Заавал өндөр байшин барих бус төвлөрсөн дулаан хангамж, дэд бүтцийн асуудал юм. Тэгэхээр 8 хувийн зээл байснаараа шууд бусаар утааг бууруулж байна. Нөгөө талаас нийгмийн даатгалын төлөлтийг сайжруулж байна. Ажлын байрандаа тогтвортой суурьшилтай ажиллах хүсэл, эрмэлзлийг бий

болгож байна. Залуучуудад орон сууцтай болох хүсэл эрмэлзэл, зорилгыг нь бий болгож өгч байна. Энэ мэт шууд бус үр дүнг нь харгалзаж үзэх хэрэгтэй болов уу.

**ИРГЭД ХҮССЭН ОРОН СУУЦАА
АВАХ ГЭХЭЭР БАНКУУД
ӨӨРСДИЙН САНХҮҮЖҮҮЛСЭН
ОРОН СУУЦЫГ САНАЛ БОЛГООД
БАЙНА ГЭХ ГОМДОЛ БАЙДАГ?**

-Энэ эрсдэлийн менежмент юм. Банк өөрийнхөө актив дээр барилгын зээл өгчихсөн байгаа. Би өнөөдөр нэг компанид 5 тэрбум төгрөгийн орон сууцны зээл олгочихсон байгаа. Тэр барилга нь борлогдохгүй бол би 5 тэрбум төгрөгөө алдах гээд байна шүү дээ. Санхүүгийн тогтвортой байдал гэдэг утгаараа энэ чухал. Тийм учраас энэ банкуудын буруу биш. Үүний нөгөө талд иргэд бас “Та нар яахаараа ийм шаардлага тавьдаг юм, би зөвхөн энэ байрыг л авмаар байна. Та нарын эрсдэл надад хамаагүй” гээд гомдол хэлж байна. Бас л буруутгах аргагүй. Асуудал юунаас эхэлсэн гэхээр ипотекийн эх үүсвэр хумигдсан. Банкууд өнгөрсөн дээрээ сууриалаад ирээдүйгээ төсөөлдөг. Банкууд 8 хувийн зээл дандаа ингэж олгогдоно гэж төсөөлөөд, барилгын зээл ихээр олгосон. Гэтэл эх үүсвэр 4 дахин хумигдангуут хүссэн хүсээгүй тохиргоо хийгдэх шаардлагатай болсон. Тийм учраас зах зээлээс орон сууцн ипотект хамруулахаа зогсооё. Зөвхөн аж ахуйн нэгжүүдийн орон сууцанд олгоё гэж байгаа юм. Нэг хүний 5 тэрбум төгрөгөөс хамааралтай байх уу, 5 тэрбумыг 100 хүнд 50 сая төгрөг болгож өгөөд, 100

хүнээс хамааралтай байх уу гэдэг эрсдэлийн менежментийн л асуудал юм.

**ГЭХДЭЭ БАНК БАРИЛГЫН
КОМПАНИЙГ ДЭМЖЭЭД,
ӨӨРИЙНХӨӨ АШГИЙГ ХАРААД,
ИРГЭДИЙН СОНГОЛТОД
НӨЛӨӨЛӨӨД БАЙНА ГЭДЭГ
ШҮҮ ДЭЭ...**

-Бүх барилгын компани тодорхой хэмжээнд банкны зээлтэй. Тэр хэмжээгээрээ хамтын ажиллагааны гэрээтэй гэсэн үг. Асуудал юунд байна вэ гэхээр нэг хүн 3, 4 дүгээр хороололд ээж, аавынхаа хажууд нэг байр авахыг хүсч байгаа юм. Тэр орчноо мэддэг, тэндээ амьдарч дассан учраас зөвхөн тэр орон сууцыг л худалдаж авахыг хүсээд, банкин дээр очихоор “уучлаарай” л гээд байгаа юм. Та 3, 4 дүгээр хороололд байр авахыг хүсч байгаа юм байна. Гэхдээ та замынхаа хойно биш, урд нь байрлах энэ орон сууцнаас сонголтоо хийж болно гэдэг. Мэдээж тэр нь байршлын хувьд тухайн хүний хүсч байснаас арай өөр болчихно. Дээр нь үнийн хувьд шинэ байр учраас тодорхой хэмжээнд нэмэгдэж таарна. Тэгэхээр л иргэн хүн бухимдаж, уурлаад байгаа юм. Тэрнийг буруутгах аргагүй. Гэхдээ уучлаарай. Энэ бол аль нэг банк аль нэг салбарыг тусгайлан дэмжээд байгаа зүйл биш. Санхүүгийн тогтвортой байдалтай холбоотой асуудал. Асуудлыг том зургаар нь харж, ойлгоосой л гэж хүсч байна.

ЯРИЛЦАНД БАЯРЛАЛАА.



МОНГОЛБАНКНААС УЛИРАЛ БҮР ЭРХЛЭН ГАРГАДАГ
"МӨНГӨ-САНХҮҮ-БАЯЛАГ" СЭТГҮҮЛИЙН ТАВ ДАХЬ
ДУГААРААС ОНЦЛОВ.



“ЭДИЙН ЗАСГИЙН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ, ЦААШДЫН ЧИГ ХАНДЛАГА-2018” ХЭЛЭЛЦҮҮЛГИЙН ТОЙМ

Монголбанк, Монгол улсын их сургууль, МУИС-ийн Эдийн засгийн судалгаа, эрдэм шинжилгээний хүрээлэнгээс хамтран “Эдийн засгийн өнөөгийн байдал, цаашдын чиг хандлага • 2018” хэлэлцүүлгийг 2018 оны гуравдугаар сарын 13-ны өдөр амжилттай зохион байгуулсан бөгөөд энэхүү хэлэлцүүлэгт их, дээд сургууль, судалгаа, шинжилгээний байгууллагын эрдэмтэн, судлаач, багш, банк, санхүү, төрийн болон төрийн бус байгууллагын төлөөлөл оролцлоо. Тус хэлэлцүүлгийн хүрээнд нийт 16 илтгэл тавигдсан бөгөөд Монголбанкнаас дараах таван илтгэлийг танилцуулсан юм.

Түүнчлэн хэлэлцүүлгийн салбар хуралдаанаар “Монгол улс дахь гадаадын шууд хөрөнгө оруулалт”, “Уул уурхайн салбарын хөгжлийн стратеги”, “Уул уурхайн салбараас орох орлогын удирдлага” зэрэг асуудлаар өргөн хүрээнд хэлэлцүүлэг өрнүүлээ.

ИЛТГЭЛ 1. Байгалийн баялагтай эдийн засаг дахь мөнгөний болон макро зохистой харьцааны бодлогын нөлөө: Монголын жишээн дээр

Эхний илтгэлийг Монголбанкны Судалгаа, статистикийн газрын захирал Д.Ган-Очир тавилаа.

Тэрбээр: “Байгалийн арвин нөөц баялагтай орнууд бүтцийн хувьд уул уурхайн салбараас хэт хамааралтай байдаг бөгөөд макро зохистой бодлого нь эдгээр улс орнуудын анхаарлын төвд байдаг учраас тус судалгааны ажлаар мөнгөний болон макро зохистой бодлогын нөлөөг судлахыг зорьсон юм. Уг судалгааны ажлаар мөнгөний болон макро зохистой бодлогын нөлөөг жижиг, нээлттэй эдийн засгийн динамик стохастик ерөнхий тэнцвэрийн загварын шугаман тэгшитгэлүүдэд тулгуурлан манай орны 2005 оны нэгдүгээр улирлаас 2017 оны хоёрдугаар улирлын

тоон мэдээг ашиглан Бейсийн эконометрик аргаар үнэлсэн болно. Энэхүү судалгааны үр дүнд:

Гадаад шокын монголын эдийн засагт үзүүлэх нөлөө хүчтэй байна. Учир нь ДНБ-ий вариацийн 25-аас багагүй хэсгийг гадаад шок тайлбарлаж байна, мөн түүхэн хугацаанд гадаад шокууд мөчлөгийн үндсэн хүчин зүйл болж ирсэн болохыг эмпирик байдлаар нотлон харууллаа.

Мөнгөний болон макро зохистой бодлогыг хослуулан ашиглах хэрэгтэй. Учир нь бодлогын хүү нь валютын ханш, инфляцийн хэлбэлзэлд нөлөөтэй. Харин заавал байлгах нөөц, өөрийн хөрөнгийн харьцаа нь зээлийн өсөлтөд бодлогын хүүтэй харьцуулахад илүү нөлөөтэй байна.

Мөн түүнчлэн цаашид тус загварчлалыг илүү сайжруулах шаардлагатай. Тухайлбал, гадаад шокын төсвөөр дамжих сувгийг илүү нарийн загварчлах, бодит болон санхүүгийн салбарын уялдаа холбоог сайжруулах, салбарын BVAR болон DSGE загварыг хөгжүүлэх, Behavioral (зан төлөвийн) макро загварчлалыг хөгжүүлэх шаардлагатай байна” гэж илтгэлдээ онцолсон юм.

ИЛТГЭЛ 2. Экспортын төрөлжилт ба эдийн засгийн өсөлт

Хоёр дахь илтгэлийг Монголбанкны Судалгаа, статистикийн газрын судалгааны хэлтсийн эдийн засагч Б.Хүслэн “Экспортын төрөлжилт ба эдийн засгийн өсөлт” сэдвээр тавьлаа. Тус илтгэлд: “Орчин үед улс орны харьцангуй давуу талыг байгалийн баялаг бус,

тухайн улсын цогц байдал (complexity) илэрхийлдэг болжээ. Олонх эрдэмтэн, судлаачид бүтээгдэхүүний төрөлжилт, нэмүү өртөг шингээсэн байдал нь эдийн засгийн өсөлтийн ихэнх хувийг тайлбарлаж байгааг эмпирик судалгаагаар нотлон харуулсан байна. Улс орнууд ч мөн адил экспортыг төрөлжүүлэх стратегийг эдийн засгийн цогц байдлын индекс (economic complexity index), бүтээгдэхүүний орон зайн шинжилгээг ашиглан боловсруулж байна. Энэхүү судалгааны ажлын зорилго нь Монгол улсын экспортын бүтцийг хамгийн үр ашигтайгаар төрөлжүүлэхэд тэргүүлэх салбар, бүтээгдэхүүнийг тодорхойлоход оршино. Манай оронд экспортыг хөгжүүлэх суурь орчин, оновчтой дэд бүтцийн шийдэл байхгүй байна. Тухайлбал, манай орон газарзүйн байршлын хувьд хоёр том гүрэнтэй хиллэдэг тул тухайн хоёр орны гадаад бодлогоос шууд хамааралтай. Экспортыг дэмжих бодлого байгаа ч тогтворгүй байдаг, мөн хэрэгжүүлэх стратеги, арга хэрэгсэл нь тодорхойгүй байдаг учраас хэрэгжилтийн түвшин хангалтгүй байсан ажээ. Улсын төсвөөс санхүүждэг, байнгын үйл ажиллагаатай, санхүүгийн чадавх болон ажилтнуудын тоо хүрэлцээтэй экспортыг дэмжих байгууллага байхгүй байна. Монгол улсын нэрлэсэн зээлийн хүү нь хөгжингүй орнуудтай харьцуулахад өндөр байгаа нь гадаад худалдаанд жижиг дунд эрхлэгчдийг өрсөлдөх чадварыг дээшлүүлэхэд саад учруулж байна. Манай оронд гадаад худалдааны, тэр дундаа экспортын санхүүжилтийн үйлчилгээ

хомс байдаг. Экспортын орлогыг бүрдүүлж буй бүтээгдэхүүний бүтцийг авч үзвэл, уул уурхайн салбарын бүтээгдэхүүн хэт давамгайлсан, нэг салбараас хэт хамааралтай бүтэцтэй байна. Экспортын бүтээгдэхүүний төрлийн зохистой харьцаа алдагдсан тул уул уурхайн бус салбарын бүтээгдэхүүний экспортыг нэмэгдүүлэх замаар экспортын төрлийг солонгоруулан, орлогын эрсдлийг бууруулах шаардлагатай байна. Эдийн засгийн цогц байдлын индекс (ECI) нь эдийн засгийг зөвхөн тодорхойлогч хүчин зүйл бус, түүний хөдөлгөгч хүч нь бас болдог байна. Иймд уул уурхайн салбарын түүхий эдийг гүнзгий боловсруулж, экспортод гаргах, уул уурхайн бус экспортын тэргүүлэх салбар, бүтээгдэхүүнийг ECI-д үндэслэн тогтоох шаардлагатай байна. Эдийн засгийн цогц байдлын индекс, бүтээгдэхүүний орон зайн шинжилгээг ашиглан манай орны экспортыг хамгийн үр ашигтайгаар төрөлжүүлэх боломжтой бүтээгдэхүүнийг тодорхойлоо. Монгол улс нь богино хугацаанд хүдэр, үнс хөө; савхи, арьсан бүтээгдэхүүн; ноос, амьтны үс; түлш, газрын тос; мах зэрэг бүтээгдэхүүний экспортыг дэмжсэнээр төрөлжилтийг хамгийн үр ашигтайгаар бий болгох боломжтой байна. Харин дунд болон урт хугацаанд хүнд үйлдвэрийн машин болон химийн гаралтай бүтээгдэхүүнүүд болох үйлдвэрийн машин, түүний эд ангиуд; эмийн бүтээгдэхүүн; альбуминоидын бодис, цавуу, энзим; модны целлюлоз, цаас, цаасан карт; эфирийн тос, үнэртэн,

гоо сайхны бэлдмэл зэрэгт илүү анхаарал хандуулах шаардлагатай байна” гэжээ.

ИЛТГЭЛ 3. Мега төсөл: Олон улсын туршлага, Монгол Улсын одоогийн нөхцөл байдал, эдийн засагт үзүүлэх нөлөө

Дараагийн илтгэлийг Монголбанкны Судалгаа, статистикийн газрын Судалгааны хэлтсийн эдийн засагч Д.Цэнддорж “Мега төсөл: Олон улсын туршлага, Монгол Улсын одоогийн нөхцөл байдал, эдийн засагт үзүүлэх нөлөө” сэдвээр танилцуулсан юм. “Монгол Улсад хэрэгжиж буй болон хэрэгжихээр төлөвлөж буй төслүүдийн талаар нэгдсэн мэдээлэлтэй болох, тэдгээр төсөл хэрэгжсэн тохиолдолд эдийн засагт ямар нөлөө үзүүлэх, аль салбарын хөрөнгө оруулалтын эдийн засагт үзүүлэх эерэг нөлөө өндөр байхыг судлах зорилгоор энэхүү судалгааг гүйцэтгэлээ. Дэлхий нийтэд мега төслийн хөрөнгө оруулалтын хэмжээ болон нэг төсөлд ногдох санхүүжилтийн дүн сүүлийн жилүүдэд хурдацтай өссөн бөгөөд ирэх арван жилд ч тасралтгүй өсөх хандлагатай байгаагаас харахад Монгол Улсын хувьд уул уурхай, боловсруулах үйлдвэрлэл, эрчим хүч, дэд бүтцийн салбарын төслүүдэд хөрөнгө оруулалт татах боломж өндөр байна. Олон улсад хэрэгжсэн мега төслүүдэд хийсэн судалгаагаар зардал хэтрэх, хугацаа төлөвлөснөөс сунах, үйлдвэрлэл төлөвлөснөөс бага байх нийтлэг хандлага ажиглагддаг тул төсөл бүр амжилттай болдоггүй байна. Шинжилгээний хэсгийг ҮСХ-оос боловсруулсан Салбар хоорондын тэнцлийн 2015 оны үр дүнг ашиглан хөрөнгө оруулалтын нийт



үйлдвэрлэл, ажил эрхлэлт, экспорт, импортод үзүүлэх нөлөөллийг тооцоолсон бөгөөд голлох үр дүнг дурдвал дараах байдалтай байна.

Нефть, замын салбарт оруулсан хөрөнгө оруулалт үйлдвэрлэлийг хамгийн ихээр дэмждэг бол уул уурхайн салбарт оруулсан хөрөнгө оруулалт хамгийн бага нөлөөтэй байна. Гэхдээ уул уурхайн салбарт оруулсан хөрөнгө оруулалт нь экспортыг бусад салбараас илүү дэмжиж байна.

Нэг салбарт оруулсан хөрөнгө оруулалтын бусад салбарт үзүүлэх нөлөөллийг тооцоолсон шинжилгээнээс эрчим хүч, төмөр замын салбарын бусад салбарын үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх нөлөө хамгийн их буюу тус салбарт оруулсан хөрөнгө оруулалт бусад салбарын үйлдвэрлэлийг хамгийн ихээр өсгөхөөр байна.

Бүх салбарт ижил хэмжээний хөрөнгө оруулалт хийхэд бий болох

ажиллах хүчний өөрчлөлт төмөр замын салбарт хамгийн өндөр бөгөөд металлын хүдэр олборлох салбарт хамгийн бага байна.

Мега төсөл хэрэгжүүлэх боломжтой салбараас төмөр замын салбар нь импортын орц хамгийн өндөртэй байна.

Дээрх салбарын экспорт, импортын орцын итгэлцүүрийг харьцуулахад нефть, эрчим хүч, төмөр замын салбарт оруулсан хөрөнгө оруулалт нь богино хугацаандаа төгрөгийн гадаад валюттай харьцах ханшийг сулруулах, нүүрс, металлын олборлолтын салбарт оруулсан хөрөнгө оруулалт нь дунд урт хугацаандаа ханшийг чангаруулах нөлөө үзүүлэхээр байна”.

ИЛТГЭЛ 4. Үнэ өөрчлөгдөх дундаж хугацааг тооцох нь

Удаах илтгэлийг Монголбанкны Судалгаа, статистикийн газрын судалгааны хэлтсийн эдийн засагч О.Цолмон “Үнэ өөрчлөгдөх

дундаж хугацааг тооцох нь” сэдвээр танилцуулсан. “Бид энэхүү судалгааны ажлаараа Монгол улсын хувьд нэрлэсэн үнийн хөшүүн байдлыг Хэрэглээний үнийн индекс (ХҮИ)-ийн микро тоон өгөгдөлд тулгуурлан ялгаатай хоёр аргачлалаар тооцож гаргалаа. Ашиглаж байгаа аргачлалаас хамааран үнэ тогтвортой байх дундаж хугацаа манай орны хувьд 2.3-5.7 сар байдаг. Бараа, үйлчилгээний үнэ тогтвортой байх дундаж хугацааг тооцон үзэхэд нийт бараа, үйлчилгээний дийлэнх хувийн үнэ нь дунджаар 4 хүртэлх сарын хугацаанд тогтвортой байдаг. Дотоодын барааны үнэ тогтвортой байх дундаж хугацаа 9.3 сар байдаг бол харин импортын барааны хувьд үнэ тогтвортой байх дундаж хугацаа 3.8 сартай байдаг нь уг судалгаагаар тогтоогдлоо. Үнэ тогтвортой байх дундаж хугацааг судлахад, нийт бараа, үйлчилгээний 44 орчим хувийнх нь үнэ сар бүр өөрчлөгддөгөөс харахад, үнэ дунджаар 2.3 сар тогтвортой байдгийг харуулж байна. Мөн хэрэглээний сагсны бүлгийн хувьд 2010 оноос хойш буюу манай орны эдийн засаг өсч, зах зээл харьцангуй тэлсэн үед үнэ хөшүүн буюу илүү урт хугацаанд тогтвортой болсон байна. Цаашид энэхүү судалгааны үр дүнг манай орны хувьд загварчилж буй шинэ Кейнсийн ДСЕТ загваруудын үнийн хөшүүн байдлын зэргийг калибраци хийхэд ашиглах боломжтой юм. Хэрэв ерөнхий тэнцвэрийн загварт пүүсүүд Калвогийн дүрмээр үнэ тогтоодог бол дотоодын пүүсүүдийн үнэ өөрчлөхгүй байх магадлал нь $\theta\theta\theta\theta=0.86$, харин импортлогч

пүүсүүдийн хувьд $\theta\theta\theta\theta=0.74$ байна”.

ИЛТГЭЛ 5. DMA аргыг ашиглан инфляцийг таамаглах нь

Дараах илтгэлийг Монголбанкны Судалгаа, статистикийн газрын Судалгааны хэлтсийн захирал Л.Даваажаргал “DMA аргыг ашиглан инфляцийг таамаглах нь” сэдвээр танилцуулсан юм. Тэрбээр: “Энэхүү судалгаагаар Монголын инфляцийг DMA арга хэр сайн төсөөлөхийг судаллаа. DMA арга нь загварын итгэллцүүр нь цаг хугацааны хувьд өөрчлөгдөөд зогсохгүй таамаглаж буй загвар нь өөрөө цаг хугацааны туршид өөрчлөгдөж болно гэсэн таамаглалд суурилдаг онцлогтой. Эмпирик судалгааны үр дүнгээс харахад, DMA аргыг инфляцийн төсөөлөл гаргахад ашиглах нь таамаглалын алдааг бууруулахад туслахаар байна. Өөрөөр хэлбэл, DMA аргын таамаглал нь бусад загварт авч үзсэн динамик загвартай харьцуулахад инфляцийн төсөөлөл хийхэд хамгийн бага алдаатай байхаар байна. Энэ нь манай орны хувьд төсөөллийг тайлбарлагч хамгийн сайн хувьсагчид нь цаг хугацааны туршид өөрчлөгдөж буйг давхар илтгэнэ. Тухайлбал, хугацааны энэ үед жилийн инфляцийн богино хугацаа ($h = 1$)-ны таамаглал хийхэд БНХАУ-ын инфляци болон газрын тос, цалин, M2 мөнгөний нийлүүлэлтийн жилийн өөрчлөлт чухал үүрэгтэй байна. Харин дунд хугацааны инфляцийн таамаглал хийхэд ($h = 5$) БНХАУ-ын ДНБ-ний өсөлт, газрын тос болон гадаад худалдааны нөхцөл, цалин, M2 мөнгөний нийлүүлэлтийн жилийн

өөрчлөлт чухал мэдээлэл өгөхөөр байна. Харин хугацааны өмнөх үед эдгээр хувьсагчдын зарим нь инфляцийн төсөөлөл гаргахад бараг ач холбогдолгүй байсан байна. Иймд таамаглагч хувьсагчид цаг хугацаанд өөрчлөгддөг энэхүү эмпирик баримтад суурилан цаашид DMA аргаар макро хувьсагчдын төсөөлөл гаргах нь таамаглалын үр дүнг сайжруулахаар байна” гэж илтгэлдээ дурдсан байна.

* * *

Илтгэлийн хэлэлцүүлгээр уул уурхайн бүтээгдэхүүний экспортод түшиглэсэн экспортын бүтэцтэй Монгол шиг улсын хувьд цаашдаа экспортыг төрөлжүүлэх, импортыг орлохуйц нэмүү өртөг шингээсэн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг дэмжих нь чухал. Гэхдээ импортыг орлохдоо заавал бүх зүйлийг хийх албагүй. Монголын онцлогийг шингээсэн, олон улсад өрсөлдөх чадвартай бүтээгдэхүүний экспортыг дэмжих замаар эдийн засгаа төрөлжүүлэх шаардлагатай гэдгийг оролцогчид онцолж байлаа. Мөн төрийн болон эдийн засгийн бусад томоохон судалгааны байгууллагууд хамтран эдийн засгийн төлөв байдал, цаашдын хөгжлийн чиг хандлагыг тодорхойлох, үүнд эрдэмтэн, судлаачдын санал, дүгнэлтийг тусгаж, төр засагт дуу хоолойгоо хүргэж байх иймэрхүү хэлэлцүүлгийг тогтмол зохион байгуулах нь чухал ач холбогдолтой гэдгийг оролцогчид онцолж байлаа.

МОНГОЛБАНК

ТҮҮХИЙ ЭДИЙН ДЭЛХИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН ҮНЭ
(АМ.ДОЛЛАРААР, 25/᠕ ӨДРИЙН БАЙДЛААР)



АРГЕНТИН УЛСЫН ЭДИЙН ЗАСГИЙН ЗОВЛОН



“Монголбанкны мэдээлэл” товхимлын энэ удаагийн дугаарын Олон Улсын эдийн засаг булангаар, Бүгд Найрамдах Аргентин улсад тулгараад байгаа песогийн хямралын талаар бичихээр зорилоо. Аргентин нь Өмнөд Америк тивийн урд хэсэгт оршдог бөгөөд 43.9 сая орчим хүн амтай, 2.78 сая км² газар нутагтай, Их 20-ийн бүрэлдэхүүнд багтдаг улс. Дэлхийн Банкны мэдээгээр тус улсын ДНБ 2016 онд 545.9 тэрбум ам.доллартой тэнцэж байсан бөгөөд эдийн засгийн бүтцээр нь харвал үйлдвэрлэл (20.1%), хөдөө аж ахуй (8.6%), үйлчилгээний (59%) салбаруудад түшиглэдэг. Хэдийгээр өндөр чадавхтай эдийн засагтай ч гэсэн, тогтворгүйгээр алдартай тус улс нь үндэсний мөнгөн тэмдэгт песо хямрал, цаашлаад эдийн засгийн төвөгтэй байдалд ороод байгаа билээ.

Бүгд Найрамдах Аргентин Улсын песогийн ханш зогсолтгүйгээр унаж байгаа тул Ерөнхийлөгч Маурисио Макри 5-р сарын 8-ны өдөр олон нийтийн телевизээр ОУВС-ын хөтөлбөрт хамрагдахаар болсноо мэдэгдлээ. Тэрбээр мэдэгдэлдээ “Өмнөх цаг үед улс оронд маань тохиолдож байсан явдлыг дахин давтахгүй нь тулд бид энэ алхмыг хийж байна” гэсэн. Эдийн засгийг сэргээх олон талын арга хэмжээ, реформыг хэрэгжүүлж байгаа Ерөнхийлөгч Макри мэдэгдэлдээ “өмнөх цаг үе” гэж дурдсан нь өмнө нь болж байсан гашуун түүхийн дурсамжийг сэдрээж, эргэлзээг төрүүлээ.


Тодруулбал Аргентин 1998-2002 оны хооронд эдийн засгийн их хямралд нэрвэгдсэн бөгөөд ОУВС-

ын хөтөлбөрийг хамтран хэрэгжүүлсэн боловч зорилтууддаа хүрч чадаагүйн улмаас хөтөлбөрөөс гарсан. Улмаар олгогдож байсан зээл, тусламжууд зогсож, санхүүжилтүүд татрах үед засгийн газрын 82 тэрбум ам.долларын гадаад өр дефолтод орсон байдаг. Энэ үед ажилгүйдлийн түвшин улс даяар өсч, ядуурал ихээхэн нэмэгдэж, корралитог хэрэгжүүлсэн. Корралито гэдэг нь засгийн газраас арилжааны банкуудыг дампуурахаас сэргийлж, хадгаламж эзэмшигчдийн данснаас авахуулаад бүх дансыг бүтэн жилийн хугацаанд царцаасан явдал юм. Хэрэгжүүлж байсан хөтөлбөрийн нөхцөлдөө ОУВС хатуу зогссондоо Аргентинчуудаас ихээхэн шүүмжлэл хүртдэг ч, хамгийн гол учиг нь популист засгийн газрын “мунхаг” бодлогын үр нөлөө байсныг тэмдэглэх нь зүйтэй болов уу. Тиймээс ч Ерөнхийлөгч Макригийн энэхүү алхам нь улс төрийн хувьд эрсдэлийг дагуулж байгаа ба гарцаагүй байдалд орсныг ч давхар илтгэж байгаа юм.

Он гарсаар Аргентины песогийн ханш ам.долларын эсрэг 20 орчим хувиар сулраад байгаа. Төв банкнаас нь энэ уналтыг зогсоохын тулд дараалсан арга хэмжээ авсан боловч тусыг эс олсон. 4-р сарын 23-аас 5-р сарын 4-ний хооронд Төв банкнаас 5 орчим тэрбум ам.долларыг зах зээл рүү нийлүүлж, бодлогын хүүг нийтдээ 12.75 бүхэл нэгж хувиар нэмснээр өнөөдөр 40 хувьд хүрээд байна. Сангийн сайд Николас Духовне эдийн засагт хэрэгжиж байгаа реформуудын хүрээнд төсвийн алдагдлын зорилтот түвшинг ДНБ-ний 3.2%-тэй тэнцүү байсныг 2.7% болгож бууруулсан нь

песогийн ханшийг тогтворжуулах давхар зорилготой байсан ч харамсалтай нь авсан арга хэмжээ болгон үр

нөлөөгөө урт хугацаанд өгсөнгүй.



Аргентин Улсын Песогийн ханш, ам.долларын эсрэг (эх сурвалж: Financial Times)

Нөгөөтээгүүр АНУ хүүгийн түвшингээ чангаруулж эхэлснээр долларын ханш чангарч хөгжиж буй зах зээлтэй (emerging market) улсуудад сөргөөр нөлөөлж эхлээд байна. 4-р сарын 24-ний өдөр 10 жилийн хугацаатай АНУ-ын Засгийн газрын бондын өгөөж 3%-ийг давсан нь 2014 оны 1-р сараас хойших анхны тохиолдол болсон. Хариуд нь 5-р сарын 8-ны өдөр Холбооны нөөцийн төв банкны тэргүүн Жером Пауэлл хөрөнгө оруулагчдад зориулж, “бодлогын хүүний өөрчлөлт нь хөгжиж буй зах зээлд мэдэгдэхүйц нөлөөлөхгүй” гэж мэдэгдсэн. Гэвч Туркийн лир, Мексикийн песо, Польшийн злот зэрэг валютуудын ханш долларын эсрэг унасаар байна.

Аргентины нөхцөл байдал хамгийн эмзэг байгаа нь хэд хэдэн үзүүлэлтүүдээр илэрхий байгаа. Юун түрүүнд инфляцийн хүлээлт энэ онд 22%-д хүрсэн нь Төв банкны зорилт болох 15%-аас өндөр байгаа. Мөн төсвийн алдагдал маш их нэмэгдэж, гадаад өр 2015 онд ДНБ-ны 26%-тай тэнцэж байсан бол 2017 онд ДНБ-ны 40%-д хүрсэн байна. Нөгөө талаас, хүүгийн түвшин хэт өндөр, хөрөнгийн зах зээл сул хөгжсөн зэрэг шалтгаануудын улмаас шаардлагатай санхүүжилтийг дотоодоос татаж чадахгүй байгаа бүр нэрмээс болж байна.

Аргентины Ерөнхийлөгч нь гүйцэтгэх засаглалын тэргүүнээр ажилладаг ба Макригийн өнгөрсөн хугацаанд хэрэгжүүлсэн реформист, төсвийн алдагдлыг бууруулахад чиглэсэн бодлого нь эвслийн засгийн газарт

хагарал үүсгэсэн. Түүний хэрэгжүүлж байгаа реформууд нь эдийн засгийг тогтворжуулах зорилготой боловч сөрөг хүчний эсэргүүцлүүдтэй тулгарч байгаа. Тиймээс ч Аргетиний эдийн засгийн судалгаа шинжилгээ, зөвлөгөө хүргэдэг Абекеб компаниас “эдийн засгийн урт хугацааны тогтвортой байдлыг бий болгохын төлөө улс төрийн нөхцөл байдлыг гаргууд нь гаргаж байна уу даа гэсэн асуултыг хөрөнгө оруулагчид тавьж байгаа” гэсэн байна.

Өмнөх Ерөнхийлөгч Кристина Фернандез Киршнер нь популист улс төрч гэдгээрээ алдартай ба түүний тарьсан балгийг болгоомжтойгоор цэгцлэх улс төрийн арга барилыг Макри хэрэгжүүлж байгаа. Түүнийг 2015 оны 12-р сард үүрэгт ажлаа хүлээж авах үед эдийн засаг нь бүрэн сүйрэлд нэрвэгдсэн байсан. Үндэсний статистикийн институтээс оны инфляцийн түвшинг 40% давсныг мэдээлж, төсвийн алдагдлыг санхүүжүүлэхийн тулд Төв банкнаас хэвлэсэн мөнгөний хэмжээ ДНБ-ний 5.4% хувьтай тэнцэж байсан. Гадаад валютын хяналт нь хиймлээр песогийн ханшийг өсгөж, экспортын татвар нэмэгдсэнээр тариаланчид хураасан тариагаа овоолж, бонд эзэмшигчидтэй өрнүүлсэн маргаан нь Аргентенийг Олон Улсын зээлийн захаас хассан.

Тиймээс ч Ерөнхийлөгч Макри ажлаа аваад яаралтайгаар гадаад валютын хяналтыг сулруулж, экспортын татварыг бууруулж, дефолтод ороод байсан бондуудыг шийдвэрлэж чадсан. Мөн төсвийн

алдагдлыг эдийн засгийн өсөлтөд сөргөөр нөлөөлөхгүй хэмжээнд алгуур бууруулахыг зорьсон ч конгрессын олонхын саналыг арай ядан авсан. Улмаар инфляцийг өсгөхгүй, олон нийтийн дунд шуугиан тарихгүй байх стратегиар нийтийн тээвэр болон ус, цахилгааны үнийг бага зэрэг нэмэгдүүлж эхэлсэн. Олон Улсаас бага хүүтэй санхүүжилт босгосноор төсвийн алдагдлыг бууруулж чадсан нь түүний өөр нэг амжилт. Хөрөнгө оруулагчид Макригийн стратегийг дэмжиж байгаа нь илэрхий байсан ба 2017 оны 6-р сард Аргентин Улсын түүхэнд анх удаа 100 жилийн хугацаатай бондыг жилийн 7.9%-ийн хүүтэй босгож чадсан.

Харамсалтай нь Макри анхаарлаа сулруулж эхэлсэн буюу Төв банк инфляцийн зорилтоо 2017 оны 12-р сард 12%-аас 15% болгож өсгөсөн цагаас эхэлж эргэлзээ үүссэн. Засгийн газар эдийн засгийн өсөлтөд хүүгийн түвшин хэт өндөр байгаа нь сөргөөр нөлөөлж байна гэсэн маргаанаас энэ бүхэн эхэлсэн аж. Үүний нөлөөгөөр Төв банк бодлогын хүүгээ 0.75 хувиар бууруулснаар инфляцийн хүлээлтийн түвшинг хөөрөгдөж орхисон. Хөрөнгө оруулагчид банкны хараат бус байдал болон инфляцийг бууруулах зорилттой байгаа эсэхэд эргэлзэж эхэлсэн. Улмаар энэ оны 4-р сард Аргентин Улс капиталын нэмэгдлийн татварыг засгийн газрын бондод нэвтрүүлснээр тогтворгүй байдлыг үүсгэлээ.



Аргентин Улсын Төв банкны бодлогын хүү (эх сурвалж: Аргентиний Төв банк)

Аргентин Улсын Төв банк песогийн ханшийн огцом уналтыг хазаарлахын тулд интервенц хийж, 8 хоногийн дотор бодлогын хүүг гурвантаа бууруулж 12.75 хувиар өсгөсөн ч тус болсонгүй. Тэдний хувьд зээл санхүүжилтүүд хэт өндөр үнээр олдох тул ОУВС-нд хандахаас өөр аргагүй нөхцөлд хүрээд байна. Эдийн засагчид ОУВС-аас уян хатан зээлийн шугам (flexible credit line)-ыг хүсэх магадлалтай байгааг мэдээлж байсан. Тус хэрэгслийг ашиглахад эдийн засгийн суурь сайтай байх, оновчтой бодлогыг хэрэгжүүлдэг байх гэсэн шалгуурыг тавьдаг. Ерөнхийлөгч эдийн засгийн реформыг хэрэгжүүлж байсан ч, энэ хоёр шаардлагын алийг ч Аргентин хангаж чадаагүй учраас ОУВС-ын стэнд-бай хөтөлбөрт хамрагдсаныг 5-р сарын 10-ны өдөр мэдэгдлээ.

Гэхдээ Ерөнхийлөгч Макригийн хувьд нөхцөл байдал аврагдахын аргагүй түвшинд хүрээгүй байна. Өөрөөр

хэлбэл 2001 оны их хямралын үеэр иргэд банкнаас хадгаламжаа их хэмжээгээр татаж байсан бол энэ удаад ийм үзэгдэл ажиглагдаагүй байна. Хэрэв песогийн хямралын хамт иргэд хадгаламжаа татаж эхэлбэл, санхүүгийн зах зээлийн тогтворгүй байдалд хүргэж улмаар эдийн засгийн хямралыг эргэлтгүйгээр эхлүүлэх аюултай юм. Мэдээж песогийн хямралд Макри улс төрийн томоохон төлөөс төлөх нь тодорхой ч, нөгөө талаас 2019 оны 10-р сар хүртэл сонгууль болохгүй учир найдвар оршсон хэвээр байгаа. Сүүлд хийсэн судалгаанаас үзэхэд Аргентинчуудын дөрөвний гурав нь ОУВС-ын хөтөлбөрт хамрагдахыг эсэргүүцсэн байна. ОУВС-нд хандах хандлаг аль улсад холимог байдаг бөгөөд Аргентин улс тус байгууллагатай хүндхэн түүхийг бичилцэж байсан тул иргэд эсэргүүцэх нь ч дамжиггүй юм.

<https://www.economist.com/finance-and-economics/2018/05/12/argentinas-economic-woes>



МОНГОЛБАНК
МОНГОЛ УЛСЫН ТӨВ БАНК



САНГИЙН ЯАМ



САНХҮҮГИЙН
ЗОХИЦУУЛАХ
ХОРОО



МВА
MONGOLIAN BANKERS ASSOCIATION



ХАДГАЛАМЖИЙН
ДААТГАЛЫН
КОРПОРАЦИ
Deposit Insurance Corporation of Mongolia



МОНГОЛЫН ИПОТЕКИЙН КОРПОРАЦИ
MONGOLIAN MORTGAGE CORPORATION



БИЧИЛ САНХҮҮГИЙН
ХӨГЖЛИЙН САН



САНХҮҮГИЙН ХЭРЭГЛЭГЧИЙГ ХАМГААЛАХ АЯН

2018 01.02-05.31